

UCS 0801A:2020

НОГООН БАЙГУУЛАМЖ



Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон
байгууламжийн төлөвлөлт

НОГООН БАЙГУУЛАМЖ

Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон
байгууламжийн төлөвлөлт



ГАРЧИГ

1	Зорилго.....	5
2	Хэрэглэх хүрээ	5
3	Норматив эшлэл	5
4	Нэр томъёоны тайлбар.....	6
5	Хотын суурины ногоон байгууламжийн төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....	8
5.1	Хот суурины ногоон байгууламжийн төлөвлөлтийн үндсэн шаардлага.....	8
5.2	Хамгаалалтын ногоон байгууламж.....	10
5.3	Цэцэрлэгжүүлэх талбайг сонгох.....	10
5.4	Ногоон байгууламжийн төлөвлөлт.....	11
5.5	Ногоон байгууламжийн тусгай төлөвлөлт.....	13
5.6	Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийг төлөвлөх.....	15
5.7	Ландшафт төлөвлөлт.....	17
5.8	Экологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт.....	18
6	Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн үндсэн шаардлага....	19
7	Хотын ногоон байгууламжийн системийн төлөвлөлт.....	22
8	Хотын ногоон байгууламжийн үзүүлэлтийг тодорхойлох.....	26
9	Хот суурин газрын ногоон байгууламжийн ангилал түүнд тавигдах шаардлага.....	28
9.1	Хот суурин газрын доторх ногоон байгууламжийн ангилал.....	29
9.2	Хот суурин газрын гаднах ногоон байгууламжийн ангилал.....	36
9.3	Тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг бүрдүүлэгч нэгж элементүүд..	39
10	Ногоон байгууламжийг тооцоолох зарчим, арга.....	43
11	Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлага.....	45
11.1	Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн ерөнхий шаардлага.....	45
11.2	Ногоон байгууламжийн тарилт, төлөвлөлт.....	46
11.3	Байр зүйн зураг төсөл.....	52
11.4	Зам, талбайн зураг төсөл.....	52
11.5	Хашлага, саадын зураг төсөл.....	55
11.6	Ногоон байгууламжийн гэрэлтүүлэг.....	56
12	Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн үзүүлэлтийг тооцоолох.....	57

13	Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт.....	58
14	Хотын ногоон байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлага.....	60
14.1	Ерөнхий шаардлага.....	60
14.2	Ногоон байгууламжийн зураг төсөл.....	62
14.3	Авто замын дагуух ногоон байгууламж.....	65
14.4	Цэцэрлэгжүүлэлтийн гүүрний зураг төсөлд тавигдах шаардлага.....	66
14.5	Цэцэрлэгжүүлэлтийн архитектурын зураг төсөлд тавигдах шаардлага.....	67
14.6	Ариун цэврийн байгууламж.....	67
14.7	Цэцэрлэгийн сандал, хогийн сав, ундны усан оргилуур.....	68
14.8	Хиймэл уул ба чулуулаг байрлуулах.....	69
14.9	Цэцэрлэгжүүлсэн талбайн гэрэлтүүлэг.....	70
14.10	Цэцэрлэгжүүлсэн талбайн уран баримал.....	70
14.11	Мод, таримал ургамлын зураг төсөлд ашиглагдах тэмдэглэгээ.....	70
14.12	Тоглоом, дасгалын төхөөрөмж.....	71
14.13	Усан хангамж.....	71
14.14	Ус зайлуулах.....	72
	Ашигласан материалын жагсаалт.....	73

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 6.1 Цогц цэцэрлэгт хүрээлэнд тавигдах шаардлага.....	20
Хүснэгт 6.2 Суурьшлын бүсэд байгуулах 1га-аас дээш хэмжээтэй цэцэрлэгт хүрээлэнд тавигдах шаардлага.....	20
Хүснэгт 8.1 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн ангилалд тавигдах шаардлага.....	26
Хүснэгт 9.1. Ногоон байгууламжийн ангиллын тайлбар.....	28
Хүснэгт 9.2. Нийтийн зориулалттай ногоон байгууламжийн ангилал.....	29
Хүснэгт 9.3. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн ангилал.....	33
Хүснэгт 9.4. Тусгай зориулалттай ногоон байгууламжийн ангилал.....	35
Хүснэгт 9.5 Хот суурин газрын гаднах ногоон байгууламжийн ангилал.....	36
Хүснэгт 9.6 Ногоон байгууламжийн үндсэн элементүүд.....	39
Хүснэгт 9.7 Цэцэрлэгжүүлэлтийн зам, талбайн хучилтууд.....	41
Хүснэгт 9.8 Архитектурын бага элементүүд.....	41
Хүснэгт 9.9 Цэцэрлэгжүүлэлтийн байгууламжууд.....	42
Хүснэгт 10.1 Ногоон байгууламжийн статистик хүснэгт.....	44
Хүснэгт 11.1 Суурьшлын бүсийн цэцэрлэгт хүрээлэнгийн нэг хүнд ноогдох талбайн хэмжээ.....	46
Хүснэгт 11.2 Ногоон байгууламжийн эдэлбэр газар, орон зайн хэмжээ, хүрэлцэн очих хугацаа.....	46
Хүснэгт 11.3 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ ногоон байгууламжийн хоорондын зай.....	49
Хүснэгт 11.4 Дамжуулах хоолой, бусад байгууламж болон ногоон байгууламжийн модны төрөл хоорондох хамгийн бага зай.....	51
Хүснэгт 13.1 Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт.....	58

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 5.1 Хамгаалалтын зурвасын хэлбэрүүд.....	10
Зураг 5.2 Зам дагуух үйлчилгээний газрын ногоон байгууламж.....	12
Зураг 5.3 Үйлдвэрийн газрын ногоон байгууламж.....	13
Зураг 5.4 Голын эргийн дагуух ногоон байгууламжийн төлөвлөлт.....	14
Зураг 5.5 Дугуйн зогсоолын ногоон байгууламж.....	15
Зураг 5.6 Байгалийн ландшафтын хэв маягийг хамгаалсан ногоон байгууламж.....	18
Зураг 5.7 Экологийн нөхөн сэргээлт.....	19
Зураг 6.1 Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн	22

Зураг 7.1 Улаанбаатар хотын ногоон байгууламжийн систем 2040.....	23
Зураг 7.2 Нуга газрын цэцэрлэгт хүрээлэн.....	24
Зураг 11.1 Зам дагуух ногоон байгууламжийн борооны усыг ашиглах төлөвлөлт.....	47
Зураг 11.2 Борооны усыг ногоон байгууламжид хуримтлуулах загвар.....	48
Зураг 11.3 Барилга байгууламжийн гадна хананаас алслах зай.....	49
Зураг 11.4 Барилга байгууламжийн өмнөх зорчих хэсгийн төлөвлөлт.....	50
Зураг 11.5 Барилга байгууламж гадна хана, тоног, шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зайн хэмжээ.....	50
Зураг 11.6 Авто замын хашлаганы захаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ.....	51
Зураг 11.7 Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийг алслах зайн хэмжээ.....	51
Зураг 11.8 Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зай.....	51
Зураг 11.9 Түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ.....	52
Зураг 11.10 Гудамж замын дагуух цахилгааны шугамаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ.....	52
Зураг 11.11 Явган хүний зам.....	53
Зураг 11.12 Налуу замд хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй хүний түр амрах хэсэг.....	54
Зураг 11.13 Усан байгууламж.....	55
Зураг 14.1 Ногоон байгууламжийн борооны усыг ашиглах загвар.....	62
Зураг 14.2 Мод таримал ургамлын хослол зохиомж.....	63
Зураг 14.3 Амралтын талбайд модлог ургамлыг төлөвлөх.....	64
Зураг 14.4 Хоёр урсгалтай авто замын ногоон зурвасыг төлөвлөх.....	65
Зураг 14.5 Цэцэрлэгжүүлсэн талбайн явган гүүр.....	66
Зураг 14.6 Зөөврийн ариун цэврийн байгууламж.....	68
Зураг 14.7 Цэцэрлэгжүүлэлтэд байрлуулсан хиймэл чулуу.....	69
Зураг 14.7 Навчит, мод, сөөгийн тэмдэглэгээ.....	70
Зураг 14.8 Шилмүүст модны тэмдэглэгээ.....	70
Зураг 14.9 Хэлбэржүүлээгүй зүлэг	71
Зураг 14.10 Холимог зүлэг (цэцэг, зүлэг)	71
Зураг 14.11 Хэлбэржүүлсэн зүлэг	71
Зураг 14.12 Борооны усны урсах чиглэл.....	72

ОРШИЛ

Монгол улсад хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэж, Улаанбаатар хот бүхэлдээ өргөжин тэлж хотын экологийн орон зайд тулгамдсан асуудлууд болох агаарын бохирдол, замын хөдөлгөөний түгжрэл, ногоон байгууламж, усны нөөцийн хомсдол, хөрсний бохирдолд өртөж хот суурин газрын иргэдийн эрүүл амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Бидний ирээдүйн сайн сайхан байдал нь хот суурин газрын төлөвлөлтийн ур чадвараас хамаардаг бөгөөд иргэдийн амьдрах орчныг сайжруулах шаардлагатай байгаа тул аж ахуй нэгж байгууллага орон нутгийн захиргаа хамтран ажиллах харилцаа холбоог эрх зүйн баримт бичгээр зохицуулах нь зохистой юм.

Хот суурин газарт зураг төсөл, тохижилтын ажил гүйцэтгэгч хувь болон албан байгууллага, хяналтын үүрэг гүйцэтгэгч байгууллага нь иргэдийн ажиллаж, амьдрахад тохиромжтой эрүүл аюулгүй нөхцөлийг хангасан, хотын тааламжтай орчин бий болгон төлөвлөх, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа түүний явцад тулгамдаж байгаа асуудалд чиг баримжаа олгох, ландшафтын архитектурын орон зайн зохиомжийг төлөвлөх, гүйцэтгэхэд энэхүү баримт бичгийг зөвлөмж болгон ашиглана.

Баримт бичгийг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04, Хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам, Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл, Хот байгуулалтын тухай хууль, Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө, Орос болон Хятад улсын “Хотын ногоон байгууламжийн ангиллын стандарт, олон улсын ангиллын систем зэрэг баримт бичгийг үндэслэн хотын ногоон байгууламжийн үндсэн шаардлага, ландшафт төлөвлөлтөд тавигдах шаардлага, орон сууцны ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлтийн үндсэн шаардлага материалыг боловсруулав.

НОГООН БАЙГУУЛАМЖ

Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлт

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн зураг төсөл боловсруулах болон ландшафтын архитектур төлөвлөлтийн ажлын гүйцэтгэх үйл ажиллагаанд нэгдсэн арга зүйн удирдамж өгч иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

2. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн зураг төсөл боловсруулах болон ландшафтын архитектур төлөвлөлтийн ажил гүйцэтгэх, иргэн, аж ахуй нэгж, байгууллага, зөвлөх, энэ чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллага дагаж мөрдөнө.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Баримт бичигт олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын болон норм, нормативын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд тухайн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална.

- БНБД 21-05-10. Авто зогсоолын норм ба дүрэм
- БНБД 23-05-10. Дуу чимээ тусгаарлалт.
- БНБД 30.01.04. Хот, тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм.
- БНБД 30-02-07. Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө.
- БНБД 31-01-10. Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт.
- БНБД 31-03-03. Олон нийт иргэний барилга.
- БНБД 32-01-04. Хот суурины гудамж, зам төлөвлөлт.
- БНБД 3.01.03.88. Тохижилтын ажил.
- БНБД 3.01.06.90. Барилгын орчны тохижилтын ажил.
- БД31-113-11. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт.
- MNS 5682:2006. Авто замын байгууламж, Дугуйтай зорчигчийн зам. Техникийн шаардлага.
- MNS 5683:2006. Авто замын байгууламж, Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн

шаардлага.

- MNS 5879:2012. Нийтийн тээвэр, замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага
- MNS 5973:2009. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай.
- MNS 6055:2009. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар.
- MNS 6392:2013. Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Ландшафт- гэж тухайн газар нутгийн ургамлын бүрхэвч, гадаргуугийн тогтцоор илэрхийлэгдэх байгалийн дүр төрх;

Ландшафтын архитектур төлөвлөлт- гэж хүрээлэн буй орчин, архитектурын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой уран сайхны дүр төрх агуулсан цогц найрлагад нэгтгэн, нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтыг урлагийн илэрхийлэлтэй зураг төсөл гаргах юм;

Ногоон байгууламжийн ангилал- гэж байршил, нутаг дэвсгэр, үйл ажиллагааны зориулалтаас хамааран ногоон байгууламжийг системчлэх;

Хотын ногоон байгууламж- гэж хотын иргэдийн аялж амрах, орчны үзэмжийг нэмэгдүүлэх, хамгаалах зэрэг төрөл бүрийн ногоон байгууламжийн ерөнхий нэр томьёо;

Хотын ногоон байгууламжийн систем- гэж хотын ногоон байгууламжийн харилцан уялдаатай, жигд хуваарилалтыг хотын архитектур, төлөвлөлтийн байгууллагаас тодорхойлж, цаашдын хөгжлийн төлөвлөгөөг гаргах систем;

Нийтийн зориулалттай ногоон байгууламж- гэж амралтын янз бүрийн хэлбэрт зориулагдан тохижуулсан талбай;

Цэцэрлэгт хүрээлэн- гэж олон нийтэд нээлттэй, амрах гол зориулалттай, экологи, байгалийн үзэмж, соёл боловсрол, онцгой байдлаас сэргийлэх үүрэг ажиллагаатай, тодорхой үйлчилгээний байгууламжтай ногоон байгууламж;

Цогц цэцэрлэгт хүрээлэн- гэж төрөл бүрийн нийтийн үйл ажиллагаа зохион байгуулахад тохиромжтой, амрах болон үйлчилгээний байгууламж сайтай ногоон байгууламж;

Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн- гэж төрөлжсөн агуулга эсвэл хэлбэртэй, амрах болон үйлчилгээний талбай бүхий ногоон байгууламж;

Ургамлын цэцэрлэгт хүрээлэн (Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн)- гэж судалгаа, боловсролын зорилгоор мод, сөөг, өвслөг ургамлын цуглуулгыг багтаасан тусгай зориулалтын ногоон байгууламж;

Гамшгаас урьдчилан сэргийлэх чадамж бүхий ногоон байгууламж- гэж хотод

гамшиг үүсэх буюу гамшигийн дараа дахин бүтээн байгуулалт хийх явцад оршин суугчдыг тараах буюу төвхнүүлэхэд ашиглах ногоон байгууламж;

Авто замын дагуух ногоон байгууламж- гэж авто замын дагуух ногоон байгууламж нь дуу чимээ бууруулах, агаарыг цэвэршүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор замын хоёр тал болон тусгаарлах бүсэд мод, цэцэг, зүлэг таригдсан газрыг хэлнэ;

Задгай ногоон байгууламж- гэж нийтийн зориулалттай ногоон байгууламж юм;

Ургамлын улирлын шинж чанар- гэж ургамлын навч, цэцэг, жимс, холтосны улирал бүрд үзүүлэх чимэглэлийн шинж чанар;

Ногоон байгууламжийн зураг төсөл- гэж ургамлын экологийн дасан зохицол, ногоон байгууламжийн дизайны шаардлагын дагуу төрөл бүрийн ургамлуудын чиг үүрэг, гоёл чимэглэлийн шинж чанарыг харгалзан зохистой зохиомжилсон зураг төсөл;

Эртний ба ховор модны төрөл зүйл- гэж эртний мод гэдэг нь зуу гаруй жилийн настай модыг хэлнэ. Ховор мод гэдэг нь ихэвчлэн үнэт, ховор, түүхэн, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл, дурсгалт зэрэг утга учир бүхий чухал модыг хэлнэ. Түүхэн болон орчин үеийн алдартнуудын тарьсан мод, эсвэл түүхэн үйл явдал, домог болон бусад байгалийн ба соёлын үндэс суурь бүхий мод байж болно;

Хөрсний налуугийн өнцөг- гэж хөрс нь байгалийн нөхцөлд хуримтлагдаж өөрөө буй болсны дараах налуу гадарга буюу газрын гадарга хоёрын хооронд үүссэн хамгийн их өнцөг;

Өндөрлөг- гэж эх газрыг түвшний гадаргуу болгож 0 цэгээс (гадаргуугийн эхний цэг) эхлэн газрын гадаргаас хэмжих цэг хүртэлх өндрийн зайг хэлнэ;

Налуу газрын хамгаалалт- гэж налуу газрын хөрс өөрчлөгдөхөөс (хөрсний нуралт) урьдчилан сэргийлж хамгаалах ажил;

Тулгуур хана- гэж налуугийн хөрс нурахаас сэргийлж барьсан хана;

Усанд байрлуулсан гишгүүр шат- гэж хүмүүс голын дээгүүр алхах боломжтой усанд байрлуулсан гишгүүр чулуу;

Цэцэрлэгт хүрээлэнгийн барилга- гэж хотын ногоон байгууламж доторх тодорхой ашиглалтын функц, гоёл чимэглэлийн үнэ цэнэ бүхий өнгө үзэмжийг бүрдүүлдэг уран барилга юм;

Цэцэрлэгт хүрээлэнгийн тусгай барилга- гэж ногоон байгууламжид амьтны тор, хүлэмж, газар доорх барилга, усан доорх барилга, амралт зугаалгын барилга гэх мэт тусгай хэлбэр, үүрэг бүхий барилга байгууламжуудыг хэлнэ;

Бичил цэцэрлэг- гэж 1 га хүртэлх цэцэрлэгжүүлсэн амрагч, аялагчдын ая тухтай байлгах зориулалттай жижиг байгууламж;

Ногоон хана- гэж хүний хараанаас төвшнөөс өндөр ногоон элементийг хэлнэ;

Хиймэл толгод- гэж шороо, чулуу болон бусад материалыг ашиглан байгалийн уулын үзэмжийг дуурайлган зохиомлоор барьсан байгууламж бөгөөд тохижуулах эсвэл авирах зориулалтаар ашигладаг;

Хуванцар хиймэл чулуу- гэж хуванцар материалаар хийсэн дуураймал уулын чулуу;

Тэмдэг, тэмдэглэгээ- гэж ногоон байгууламжид байрлуулсан тэмдэглэгээ, анхааруулах тэмдэг, зааварлах тэмдэг гэх мэт;

Усан дээрх байгууламж- гэж нуур, гол, далайн эрэг дээр, усны гадаргууд байрлуулсан байгууламж бөгөөд усан сан руу амрагч, аялагчдыг ойртох боломжийг олгодог;

Хиймэл цөөрөм- гэж экологийн цэвэршүүлэх функцтэй байгалийн ба хиймэл цөөрөм бөгөөд борооны усыг цуглуулах, хадгалах зорилгоор ашигладаг усан хангамжийн гол эх үүсвэр;

Борооны ус хураах хиймэл намгархаг газар- гэж хур тунадасны урсцын чанар, оргил урсгалыг хянах зорилготой байгалийн намгархаг газрын бүтэц, үйл ажиллагааг дуурайсан хиймэл намгархаг газар юм;

Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн хувь хэмжээ- гэж орон сууцны хорооллын эдэлбэр газрын доторх төрөл бүрийн ногоон байгууламжийн нийт талбайн хэмжээ болон суурьшлын бүсийн цэвэр талбайтай хэмжээтэй харьцуулсан харьцаа;

Төвлөрсөн ногоон байгууламж- гэж орон сууцны хорооллын амралт, дасгал хөдөлгөөн хийх зориулалттай хэсэгчилсэн буюу зурвас ногоон байгууламж;

Барилгын хажуугийн ногоон байгууламж- гэж орон сууцны хорооллын эдэлбэр газар доторх барилга байгууламжийн орчны ногоон байгууламж;

Экологийн хяналтын шугам- гэж хот дотор тогтоосон экологийн чухал орон зайг зорилго болгон экологийн хатуу хамгаалалттай үзэсгэлэнт газрууд гэх мэт хууль эрх зүйн хамгаалалтын орон зайг заана;

Экологийн орон зай- гэж хот дотор экологийн чухал элементүүдийг хамгаалах, экологийн орон зайн бүтцийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, экологийн аюулгүй байдлыг хангах, аялал жуулчлалын газрыг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хамгаалахад чухал үйлдэл үзүүлэн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хянах шаардлагатай бүх төрлийн ногоон орон зайн хэрэгцээг буй болгоно;

5. ХОТЫН СУУРИНЫ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1 ХОТ СУУРИНЫ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ШААРДЛАГА

5.1.1. Хотын суурины ногоон байгууламжийн төлөвлөлтөд доорх зарчмыг баримтлах хэрэгтэй.

- Байгалийн ландшафтын онцлог ба уул, усны экологийн систем, түүний аюулгүй байдал, тэнцвэртэй байдлыг хамгаална;
- Хотын экологийн хамгаалалт ба бүтээн байгуулалтын байршлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөж экологийн нэгдсэн системийг буй

болгоно;

- Хот суурин газрын аялал жуулчлал, үйлчилгээний түшинг нэмэгдүүлж, ногоон байгууламжийн ерөнхий нөхцөлийг сайжруулна;
- Тухайн газрын онцлогийг төлөвлөлтөд тусгах зарчмыг баримталж байгалийн үзэмж, түүх соёлын их өвд түшиглэн ногоон байгууламжийн дүр төрхийг илэрхийлнэ;

5.1.2 Хотын ерөнхий төлөвлөлтөд хотын ногоон байгууламжийн системийн байршлыг багтаана.

5.1.3 Хотын ногоон байгууламжийн системийг хөгжүүлэх зорилт, гүйцэтгэлийн хэтийн хугацааг хослуулж хотын байршил, аж ахуй, нийгмийн байдалд тулгуурлан цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн хөгжлийн хэр хэмжээг зохицуулна.

5.1.4 Хотын ерөнхий төлөвлөлт дэх ногоон байгууламжийн системийн хөгжлийн хандлагыг баримтлан бүс нутгийн ногоон байгууламжийг хүн амын тоонд харьцуулан талбай хэмжээг тогтоож, бүтэц ба түвшний байдлыг тодорхойлон том хэмжээний ногоон байгууламж, хамгаалан тусгаарлах ногоон байгууламж зэргийг бүтээх шаардлагыг тогтооно. Ногоон байгууламжийн харьцааг бодох арга нь тус зөвлөмжийн А.1 томъёогоор тооцно.

5.1.5 Хотын ногоон байгууламжийн системийн төлөвлөлтийн хугацааг хотын ерөнхий төлөвлөлттэй адил хийж, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлно.

5.1.6 Хот суурины ногоон байгууламжийн бүсийн бүтцийг тодорхойлж, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж, аюулаас хамгаалах байгууламж ба талбайн ашиглалтыг төрөлжүүлэн ангилж хяналтын шаардлага, мэргэжлийн төлөвлөгөө болон ойрын хугацаанд бүтээн байгуулах төлөвлөлтийг боловсруулна.

5.1.7 Хотын ногоон байгууламжийн системийн тусгай төлөвлөлт нь цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн бүтэц болон гүйцэтгэл, төрөл бүрийн экологийн орон зайг хянаж, бүтээн байгуулалт, арчилгаа, хяналтыг хэрэгжүүлэх замаар хот цэцэрлэгжүүлэлтийн одоогийн байдлын хөгжлийн түвшнийг баримжаална.

5.1.8 Төлөвлөлтийн хүрэн дэх ерөнхий, дүүргийн, тусгай болон аялал жуулчлалын цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын хүрээлэн тус бүрийн ашиглалт болон хамгаалан тусгаарлах ногоон байгууламжийн чиглэлийн тодорхойлолтыг нарийн төлөвлөж хяналт ба гүйцэтгэл, ойжуулалтын заагийн ерөнхий зохицуулалтыг төлөвлөнө.

5.1.9 Хотын ногоон байгууламжийн төлөвлөлт нь байгалийн нөхөн сэргээлтийг хотын нөхөн сэргээлтийн чадамжтай уялдан хаягдмал газрыг ашиглан хотын экологийн орчныг сайжруулна.

5.2 ХАМГААЛАЛТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ

5.2.1 Хот суурин газарт усны нөөц газарт ашиглах талбай, өргөлтийн насос станцын эргэн тойронд хамгаалалтын ногоон байгууламжийг байгуулж, өргөнийг 3-аас дээш эгнээ мод, сөөгийг төлөвлөнө.

5.2.2 Хот суурин газрын бохир ус цэвэрлэх байгууламжийн эргэн тойронд хамгаалалтын ногоон байгууламжийг байгуулах, шинээр цэвэрлэх байгууламжийг тойрсон хамгаалалтын ногоон байгууламжийг бохирын цэвэрлэх зураглал, бохирын чанар, цэвэрлэх гүн, цэвэрлэх технологи, барилгын хэлбэр зэрэг хүчин зүйлээс хамааруулан тусгайлан тогтооно.

5.2.3 Хот суурин газрын ахуйн хог хаягдлын эрүүл ахуйн хогийн цэгийг тойруулан хамгаалалтын ногоон байгууламжийг байгуулж, хамгаалалтын ногоон байгууламжийн өргөнийг тогтооно.

5.2.4 Хот суурин газрын доторх гол мөрөн, нуур болон бусад усан сан бүхий газрын эрэг дагуу тогтоосон хамгаалалтын ногоон байгууламжийн өргөн нь 30 м-ээс багагүй байна.



Зураг 5.1 Хамгаалалтын зурвасын хэлбэрүүд

5.3 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙГ СОНГОХ

5.3.1 Талбайд ашиглах газрыг сонгоход дараах шаардлагыг баримтална.

- Хотын өнгө үзэмж, соёлын онцлог шинж чанарыг харуулахуйц газар байна;
- Нэгээс доошгүй хотын төв замтай холбогдсон нийтийн тээврийн зогсоолын зохион байгуулалттай хослуулна;
- Нийтийн удирдлага, үйлчилгээнд ашиглах газартай уялдсан байх. Газар ашиглалт, үйлчилгээний байгууламжийн газар, тээврийн товчооны газрын зохион байгуулалттай зохицсон байх хэрэгтэй;
- Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж ба ногоон замын зураг төслийг хослуулах нь зүйтэй;

5.3.3 Талбай байгуулах газрын хатуу хучилттай талбайн эзлэх хувийг талбайн хэлбэр ба аялагчдын цар хүрээний дагуу тодорхойлж, ногоон байгууламжийн харьцаа 35% -аас их байна.


5.3.4 Талбай байгуулах газарт түүний хамгаалалтын алба, амралт, үйлчилгээний чиг үүрэгт хамааралгүй барилга барихыг хориглоно. Барилгын талбайн эзлэх хувь 2% -аас ихгүй байна.

5.4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

5.4.1 Хот суурины ногоон байгууламжийн төлөвлөлтөд орон сууц, нийтийн менежмент, худалдааны үйлчилгээ, аж үйлдвэр, логистик, агуулах, тээврийн хэрэгсэл, нийтийн байгууламж болон бусад туслах ногоон байгууламжийн төлөвлөлтийн агуулгыг багтаасан байна.

5.4.2 Орон сууцны зориулалттай газар нутагт оршин суух газрын ногоон байгууламжийг байгуулахдаа нээлттэй, иж бүрэн хэлбэр, шаардлагатай байгууламж, талбайн тохиргоог оновчтой хийж, хор нөлөөгүй ургамлыг сонгох зарчмуудыг баримтална.

5.4.3 Төр, нийтийн үйлчилгээний газар, худалдаа үйлчилгээний байгууламжийн газрын ногоон байгууламжийн хэмжээг талбайн хэмжээ, хэлбэр, үйл ажиллагааны төрлөөс хамааруулан тусгайлан тогтоосон байна.



Зураг 5.2 Зам дагуух үйлчилгээний газрын ногоон байгууламж

5.4.4 Үйлдвэрлэлийн газар, логистик агуулахын талбайн ногоон байгууламжийн хэмжээ 20% -аас ихгүй, хортой хий, бохирдол үүсгэдэг үйлдвэрлэлийн газар, аюултай бараа хадгалдаг буюу хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг логистик агуулах нь үйлдвэрлэл, тээвэрлэлтийн журам, аюулгүй байдлыг хамгаалах, эрүүл ахуй зэрэгт үндэслэсэн байна.

5.4.5 Үйлдвэрлэлийн зориулалттай газрын ногоон байгууламжийн зураг төсөл нь дараах шаардлагыг хангасан байна.

- Ногоон байгууламжийг ажилчдын амралтын төвлөрсөн хэсэг, захиргааны оффисын талбайн ашиглалт, үйлчилгээний бүсэд сонгоно;
- Хамгаалалтын ногоон байгууламжийг хүрээлэн буй орчны аюулгүй байдлын онцгой шаардлага тавигдах хэсгүүдэд байгуулна;
- Хортой хий, тоос ялгаруулдаг, өндөр дуу чимээ гаргадаг үйлдвэрлэлийн цех, байгууламж, агуулахын талбайг жилийн туршид салхины чиг хандлага, бохирдлын шинж чанарын дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулна;
- Аюултай барааг үйлдвэрлэх, хадгалах, ачих, буулгах байгууламжийн эргэн тойронд ногоон байгууламжийн хамгаалалтын бүсийг байгуулна;



Зураг 5.3 Үйлдвэрийн газрын ногоон байгууламж

5.5 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТУСГАЙ ТӨЛӨВЛӨЛТ

5.5.1 Зам дагуух ногоон байгууламжийн төлөвлөлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна;
- Хурдны зам, төв замын ногоон байгууламж нь хотын онцлог, хэв маяг зэргийг тусгасан үзэмжит замын сүлжээг бий болгоно;
- Хот суурин газрын функциональ бүсчлэлийн онцлогтой уялдаж,

цэцэрлэгийн байгалийн үзэмж, үзэсгэлэнт ойн замыг оновчтой тодорхойлно;

- Гол мөрөн, нуур, цөөрмийн эргийн зам дагуух ногоон байгууламжийг тухайн байгалийн онцлогт тохируулан байгалийн өнгө үзэмж онцлогийг тодруулна;
- Хүрээлэн буй орчны нөхцөл байдалд тохирсон, өсөлт сайтай, гоёл чимэглэлийн шинж чанараар сайтай ургамал сонгоно;



Зураг 5.4 Голын эргийн дагуух ногоон байгууламжийн төлөвлөлт

5.5.2 Эртний болон ховор төрлийн модыг хамгаалах төлөвлөгөөнд тухайн моддын лавлах бичиг, байршил, хамгаалалтын түвшин, тэдгээрийн нөөцийг зааж, хамгаалах зорилго, арга хэмжээг санал болгоно.

5.5.3 Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Ургамлын зүйл, экосистем, генетик, ландшафтын олон янз байдал гэсэн дөрвөн талаас хамгаалах арга хэмжээг санал болгох нь зүйтэй юм;
- Экосистемийн бүрэн бүтэн байдлыг хадгалах хэрэгтэй;
- Экологийн ерөнхий тэнцвэрийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг төрөл зүйл, ховордсон ургамал, тэдгээрийн амьдрах орчны орон зайн тархалт, хамгааллын хяналтын шаардлагыг тодорхой болгоно;
- Унаган ургамлын ландшафтын онцлог шинж чанарыг тодруулж, уугуул ургамлыг сонгох, хэрэглэх, сурталчлах арга хэмжээг тодорхой болгоно;
- Тохижилтод чимэглэлийн ургамлын олон төрөл, зүйл, бүс нутгийн уугуул ургамлыг ашиглах зарчмыг дагаж мөрдөн, шинээр чимэглэлийн ургамлыг санал болгоно;

5.5.4 Хотын суурины дараах хэсгүүдэд гурван хэмжээст ногоон байгууламжийг зохион байгуулах боломжтой. Үүнд:

- Барилгын нягтрал өндөр, ногоон байгууламж багатай, дулаан ялгаруулалт

өндөртэй хуучин хот дүүрэг;

- Шинэ хот суурин газрын ландшафтын гол хэсгүүд;
- Хотын төв гудамжнууд дахь гүүрэн гарц, явган хүний гүүр, хонгилууд;
- Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, нийтийн үйлчилгээ, засаг захиргааны оффисын нөхцөл байдалд тохируулна;
- Уул, гол, зам, ил задгай налуу, фасад бүхий өргөн талбайд байгуулна;



Зураг 5.5 Дугуйн зогсоолын ногоон байгууламж

5.6 ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ ТӨЛӨВЛӨХ

5.6.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн төлөвлөлтийг хотын гамшгаас урьдчилан сэргийлэх иж бүрэн төлөвлөгөөтэй уялдуулж, гамшгийг бууруулах, үндэслэлтэй тооцох, орон нутгийн нөхцөл байдал, шаталсан төлөвлөлт, системийн зохион байгуулалтын зарчмуудыг баримталж хийнэ.

5.6.2 Хотын гамшгаас урьдчилан сэргийлэх цогц системийг боловсронгуй болгоход анхаарна.

5.6.3 Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон бүсэд урт, богино ба дунд хугацааны, онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх ногоон бүс, хот суурин газрын

тусгаарлалтын орчны ногоон бүс гэсэн дөрвөн төрлийг багтаана.

5.6.4 Хотын гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийг байгуулахдаа гол төлөв богино, дунд хугацааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ногоон байгууламж, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжаар голлоно.

5.6.5 1 сая ба түүнээс дээш хот суурин газрын хүн амын төлөвлөлтөд 7 баллаас дээш хүчтэй газар хөдлөлтийн бэхлэлт бүхий хот, хотуудын нөхцөлүүд нь "урт хугацааны аюулгүй орчны ногоон орон зай, дунд хугацааны аюулгүй орчны ногоон орон зай, богино хугацааны аюулгүй орчны ногоон орон зай, онцгой байдлын аюулгүй байдлын ногоон орон зай" гэсэн дөрвөн түвшинд суурилдаг.

5.6.6 Бүх түвшний гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн цар хүрээ, зохион байгуулалт нь дараах шаардлагыг хангасан байна.

- Урт хугацааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн хэмжээ 500 000 м²-с их байх бөгөөд үүнээс үр дүнтэй зайлсхийх талбайн хэмжээ 60% -аас их байна. Хот, дүүргийн цэцэрлэгт хүрээлэнгүүд болон бусад газруудад ногоон байгууламжийн зохион байгуулалтыг хослуулах хэрэгтэй;
- Дунд хугацааны аюулгүй орчны ногоон байгууламжийн хэмжээ 200 000м²-с их, аюулгүй бүсийн талбайн хэмжээ 40% -аас их байх;
- Богино хугацааны аюулгүй ногоон байгууламжийн хэмжээ 10 000м²-с их, аюулгүй, хоргодох газрын талбайн хэмжээ 40% -аас их байна. Газар ашиглалт, цогцолборт цэцэрлэг, нийтийн цэцэрлэгт хүрээлэнтэй уялдуулна;
- Онцгой байдлаас зайлсхийх ногоон байгууламжийн хэмжээ 50 000м²-с их байх бөгөөд эрсдэлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй талбай нь 30% -аас дээш байна. Эдэлбэр газар, амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн зэрэгтэй уялдуулна;

5.6.7 Гамшгаас урьдчилан сэргийлэх, урьдчилан ногоон байгууламжийг аюулгүй байдлыг тооцсон байх бөгөөд дор хаяж яаралтай нүүлгэн шилжүүлэх хоёр сувагтай холбогдсон байх; богино хугацаанд болон аваараас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийг хурдан нүүлгэн шилжүүлэх зорилгоор суурьшлын бүсэд ойр байлгах хэрэгтэй.

5.6.8 Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх функц бүхий ногоон байгууламж нь тэгш, ил аюулгүй газарт байрлаж, дараах шаардлагыг хангасан байна.

- Газар хөдлөлтийн ан цавын бүс, үер, хөрсний нуралт, газрын суулт, хог хаягдлын урсгал болон бусад байгалийн гамшиг амархан үүсдэг газрыг сонгохгүй;
- Аюултай химийн бодис, шатамхай, тэсрэх материал, цөмийн цацраг идэвхт материал хадгалагдаж байгаа газар, өндөр хүчдэлийн дамжуулах шугам болон хувийн аюулгүй байдалд заналхийлж, сөргөөр нөлөөлөх

бусад газрыг сонгохгүй;

- Тусгай хамгаалалт шаарддаг газрыг сонгохгүй. Түүхийн цэцэрлэг, амьтан, ботаникийн цэцэрлэг, соёлын дурсгалт газар гэх мэт газрын сонгохгүй;
- Хотын үерийн хяналтын стандартаар тогтоосон үерийн усны шугамаас доогуур газарт байрлуулахгүй;
- Ногоон байгууламжийн 60% -аас дээш хувийг эзэлдэг 15% -аас дээш налуутай газарт байрлуулахгүй;
- 600 м²-с бага нээлттэй талбай бүхий ногоон байгууламжид байрлуулах ёсгүй;
- Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж дахь налуу, ус, намгархаг газар, үржүүлгийн газар, өтгөн мод, барилга байгууламж, нуранги объект 15% -аас илүү байх ёсгүй. Нурангид өртсөн газар нутагт эрсдэлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй газар болох газар доорх аюулгүй гарц, туннел байна;

5.6.9 Төвлөрсөн суурин, хуучин хот суурин газар зэрэг хүн ам шигүү суурьшсан газруудад гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор ногоон байгууламжийн зохион байгуулалтыг нэн тэргүүнд тавьж, эмнэлэг, сургууль, цэнгэлдэх хүрээлэн болон гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж болох газруудтай хамаарал бүхий зохицуулалт хийх хэрэгтэй.

5.6.10 Гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг үр дүнтэй зайлсхийх хэсгийг талбайн дагуу үндэслэлтэй тодорхойлж, урьдчилан сэргийлэх байгууламжийг гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн түвшин, чадавхад нийцүүлэн зохих ёсоор тохируулсан байна.

5.6.11 Хотын функциональ бүс, хотын нягтарсан хэсгүүд, геологийн гамшигт өртөмтгий газруудын хооронд тусгаарлах орчны ногоон бүс байгуулах;

5.6.12 Шатахуун түгээх станцууд, дэд станцууд, үйлдвэр, уул уурхайн үйлдвэрүүд, аюултай химийн бодисын агуулахууд, газрын тос, байгалийн хийн агуулахуудыг нэгтгэх шаардлагатай. Хамгаалалтын ногоон байгууламжийн тусгаарлах орчны ногоон бүсийг тохируулах хэрэгтэй.

5.7 ЛАНДШАФТ ТӨЛӨВЛӨЛТ

5.7.1 Орчны ландшафт төлөвлөлтийг хотын ерөнхий төлөвлөлттэй уялдуулж, хотын ногоон байгууламжийн онцлогийг тодруулж, тухайн бүс нутгийн байгалийн болон соёлын давуу талыг харуулах, ногоон ландшафтыг сайжруулах арга замыг санал болгох.

5.7.2 Хотын ногоон байгууламжийн ландшафтын онцлог, байрлалыг тухайн хотын мөн чанар, функциональ байршил, хэв маягийн онцлог, байгалийн ландшафт, түүх соёлын шинж чанар зэрэг хүчин зүйлээс хамаарч тодорхойлно.

5.7.3 Ногоон байгууламжийн ландшафтын бүтцийг тодорхойлохдоо байгалийн ландшафтын хэв маягийг хамгаалах, оновчтой болгох, хотын ландшафтын

ерөнхий хэв шинжийг бэхжүүлэх, хотын орон зайн бүтцийг сайжруулахад тустай зарчмуудыг баримтлах бөгөөд энэ нь хотын функциональ бүсчлэл, ландшафтын тэнхлэг, ландшафтын зангилаатай холбоотой байх. Нээлттэй орон зайн системийн зохион байгуулалтыг уялдуулан зохицуулна.

5.7.4 Ландшафтын төлөвлөлтийг ургамлын тохижилт, бүс нутгийн ландшафтын онцлог шинж чанарыг бий болгоход нутгийн ургамал, бүсийн ургамлыг ашиглахад үндэслэнэ.



Зураг 5.6 Байгалийн ландшафтын хэв маягийг хамгаалсан ногоон байгууламж

5.8 ЭКОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨЛТ

5.8.1 Ногоон байгууламжийн системийн тусгай экологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт нь хотын экологийн орон зайн нөхөн сэргээлтэд чиглүүлж, хамгаалах зарчим, ерөнхий төлөвлөлт, орон нутгийн нөхцөлд дасан зохицох, ангиллыг сурталчлах, байгалийн нөхөн сэргээлт, хиймэл сэргээн засах зэрэг ажлыг хослуулах зарчмуудыг баримтална.

5.8.2 Ногоон байгууламжийн экологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг экологийн асуудлын үнэлгээ, нөхөн сэргээх зорилгыг тодруулах, нөхөн сэргээх гол газар, төслийн жагсаалтыг тодорхойлох, нөхөн сэргээх гол төслүүдийн төлөвлөлтийн удирдамжийг санал болгох зэрэгт үндэслэнэ.

5.8.3 Хот суурин газрын уул, усан сан, орхигдсон газар, ногоон байгууламжид тулгарч буй экологийн асуудал, тэдгээрийн шалтгааныг үнэлж дүн шинжилгээ хийж, экологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай гол газруудыг тогтооно.


5.8.4 Экологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт нь үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хот байгуулалтын түвшинд нийцсэн богино, урт хугацааны нөхөн сэргээх зорилго, техникийн үзүүлэлтийг санал болгоно.

5.8.5 Сэргээн засварлалтын гол төслүүдийн төлөвлөлтийн удирдамжийг экологийн орчинд учруулсан хохирлын зэрэгт үндэслэж, нөхөн сэргээх тэргүүлэх стратегийг үндэслэлтэй сонгож, дараах шаардлагыг хангасан байх.

- Хүнд ээлтэй, экологийн орчин сайтай, экологийн хатуу чанд бүсэд

хамгаалах тэргүүлэх стратеги батлах. Хамгаалалтын шаардлага, хүний гараар хийсэн хохирол, зохиомол хөндлөнгийн оролцоог хориглох арга хэмжээ;

- Экологид илүү их хохирол учруулсан газарт инженерийн нөхөн сэргээлтийг чухалчилсан стратеги баталж, инженерийн нөхөн сэргээлт, ургамлыг сэргээх арга хэмжээг санал болгох;
- Хүний нөлөөтэй учруулсан хохирол, эвдрэлийг сэргийлж экосистемийг хэвээр хадгална.
- Байгалийн нөхөн сэргээлт хийх хүчин чадлын хүрээнд байгалийн нөхөн сэргээлтийн стратегийг баталж, байгалийн нөхөн сэргээлтийг дэмжих арга хэмжээ, инженерийн нөхөн сэргээлтийн туслах арга хэмжээг санал болгох хэрэгтэй.



Зураг 5.7 Экологийн нөхөн сэргээлт

6. ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ҮНДСЭН ШААРДЛАГА

6.1 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн байршлыг сонгохдоо дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:

- Аюулгүй байдал, бохирдолд өртөж болзошгүй газруудад байрлуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Иргэд өдөр тутмын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тохиромжтой байх;
- Хотын өнгө үзэмж, орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах;
- Хотын замтай холбогдсон нэгээс доошгүй гол гарц, туслах гарцуудыг төлөвлөх боломжтой байх;
- Байгалийн ландшафтын орон зай, түүх, соёлын болон хотын экологийг нөхөн сэргээлт хийх боломжтой газрыг сонгох;
- Уулархаг орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг байгуулахад тэгш талбай нь 20-оос доошгүй хувийг эзлэх.

6.2 Шинэ цогц цэцэрлэгт хүрээлэнгийн талбай нь 100 000м²-аас дээш байх.

6.3 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн төлөвлөлт нь барилга байгууламж, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн зам болон хучилтын талбайн харьцааг стандарт, нормын дагуу мөрдөнө.

6.4 Цогц цэцэрлэгт хүрээлэн нь хотын төв замтай холбогдсон хамгийн багадаа нэг гол гарцтай, орон зайн байршил, ландшафт, ая тухтай тээвэрлэлт бүхий хотын бүсэд давуу эрх эдлэхүйцээр байрлуулсан байх.

6.5 Цогц цэцэрлэгт хүрээлэн нь хүүхдийн тоглоом, чөлөөт цаг, амралт, спорт, соёл шинжлэх ухаан, нийтийн үйлчилгээ, худалдааны үйлчилгээ, менежментийн байгууламжууд нь хүснэгт 6.1-ийн шаардлагыг хангасан байх хэрэгтэй.

6.6 10 000м²-аас дээш орон сууц, цэцэрлэгт хүрээлэнд хүүхдийн тоглоом, чөлөөт цаг, амралт, спорт, соёл шинжлэх ухаан, нийтийн худалдаа үйлчилгээ, менежментийн байгууламжууд нь хүснэгт 6.2-ийн шаардлагыг хангасан байх хэрэгтэй.

Хүснэгт 6.1 Цогц цэцэрлэгт хүрээлэнд тавигдах шаардлага

Байгууламжийн төрөл		Цэцэрлэгт хүрээлэнгийн хэмжээ (га)		
		10~20	20~50	≥50
1	Хүүхдийн тоглоом	●	●	●
2	Чөлөөт цаг, амралт	●	●	●
3	Спорт талбай	●	●	●
4	Соёл, шинжлэх ухаан	○	●	●
5	Нийтийн үйлчилгээ	●	●	●
6	Бизнес үйлчилгээ	○	●	●
7	Цэцэрлэгийн менежмент	○	●	●
8	Барилга байгууламж	○	●	●

Тайлбар: "●" -төлөвлөлтөд зайлшгүй байх, "○"-төлөвлөлтөд заавал биш гэдгийг илтгэнэ.

Хүснэгт 6.2 Суурьшлын бүсэд байгуулах 1га-аас дээш хэмжээтэй цэцэрлэгт хүрээлэнд тавигдах шаардлага

Байгууламжийн төрөл		Цэцэрлэгт хүрээлэнгийн хэмжээ(га)		
		1~2	2~5	5~10
1	Хүүхдийн тоглоом	○	●	●
2	Чөлөөт цаг, амралт	●	●	●
3	Спорт талбай	Δ	○	●
4	Соёл, шинжлэх ухаан	Δ	○	○
5	Нийтийн үйлчилгээ	Δ	○	●
6	Бизнес үйлчилгээ	-	Δ	○
7	Цэцэрлэгийн менежмент	-	Δ	○
8	Бага оврын барилга	-	○	Δ

Тайлбар: "●" -төлөвлөлтөд зайлшгүй байх, "Δ"-төлөвлөж болно, "○"-төлөвлөх

шаардлагагүй, "°"- төлөвлөлтөд заавал биш гэдгийг илтгэнэ.

6.7 Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн нь хотын хөгжил болон экологийн бүтээн байгуулалтын шаардлагад нийцэж тухайн газрын нөхцөл байдалд тохируулан доорх шаардлагыг баримтална. Үүнд:

- Түүх, өв соёлын цэцэрлэгт хүрээлэн нь холбогдох хамгаалалтын төлөвлөлтийн шаардлагыг дагаж мөрдөх бөгөөд шаардлагатай үзмэр, амралтын газрыг багтаасан байх;
- Ботаникийн цэцэрлэг нь усны эх үүсвэр хангалттай, хөрсний чанар сайтай газарт байх.
- Хотын амьтны хүрээлэнг хотын захын хэсэгт голын эхээс доош, салхины чиглэл дагуу, үйлдвэрлэлийн бүс, бохирдлын янз бүрийн эх үүсвэрээс хол байрлуулах. Зэрлэг амьтны хүрээлэн нь хотын захад байрлах;
- Спорт, фитнесийн цэцэрлэгт хүрээлэн нь хотын суурьшлын бүсийн ойролцоо, цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон талбайн хэмжээ 65% -аас их байх;
- Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн харьцангуй тэгш газар байрлах, бохирдлын эх үүсвэрээс зайлсхийсэн, орон сууцны хороолол хүрэх зам харилцаа дөт, 20000м²-ээс их байх ба хүүхэд хөгжүүлэх агуулга, зорилго бүхий тоглоомын байгууламжаар тоноглогдсон байх;

6.8 Зам дагуух эрэг ба зурвас хэлбэртэй цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж нь аюулгүй байдал, замын хөдөлгөөн, үерийн хяналт, ачилтын шаардлагыг хангасан байх, өргөн нь 12м-аас багагүй, 30м-ээс их байвал зохимжтой, цэцэрлэгт хүрээлэнгийн зам болон амралт чөлөөт цагаа өнгөрөөх байгууламжаар хангагдсан байх;

Ургамлын цэцэрлэгт хүрээлэн





Зураг 6.1 Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн

7. ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН СИСТЕМИЙН ТӨЛӨВЛӨЛТ

7.1 Хотын ногоон байгууламжийн системийн төлөвлөлт нь зөв оновчтой, тодорхой төлөвлөх зарчим, зорилготой байх ёстой.

7.2 Хотын ногоон байгууламжийн системийн байршлыг тогтоож экологийг хамгаалан аялал жуулчлал, аюулгүй байдлыг сайтар хангасан ногоон байгууламжийн сүлжээг буй болгох.

7.3 Хотын ногоон байгууламжийн системийн зохион байгуулалт нь системлэг, бүрэн бүтэн, үргэлжилсэн гэх мэт чанаруудтай байх бөгөөд дараах байдалд нийцсэн байх:

- Хотын экологийн хамгаалах систем нь газарзүйн онцлог, экологийн онгон дагшин байдлыг хадгалан ногоон байгууламжийн экологийн сүлжээг буй болгох.
- Хотын бүсийн аялал жуулчлалын систем нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр байгаль, соёлын үзэмжийн нөөцийг зүй зохистой ашиглаж, ногоон байгууламжийн аялал жуулчлалын сүлжээг буй болгох.
- Хотын аюулгүйн систем нь хот, дүүрэг, хорооллын зах буюу хотын дотоод дахь ногоон байгууламжийн тусгаарласан бүсийг тухайн газрын салхины урсгал болон дүүргийн ногоон байгууламжийг хамгаалах, тусгаарлах бүстэй ерөнхийлөн төлөвлөж хотын экологийн нэгдмэл ногоон байгууламжийн хамгаалан тусгаарлах сүлжээг буй болгох.

7.5 Хотын экосистемийг хамгаалахдаа байгалийн болон нуга газрын хамгаалалт, экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах ой, усны эх үүсвэрийг хамгаалах ой, хөрсний нүүдлээс хамгаалах ой, салхины элэгдлээс хамгаалах ой, экологийг нөхөн сэргээх ногоон байгууламж, ховор зүйлийн амьд организмын оршин амьдрах газар зэрэг бүх төрлийн экологийн чадамжийг хамгаалах газрыг буй болгох хэрэгтэй.

- Байгалийн экологийн системийг сайтар хамгаалж биологийн олон хэлбэрийг хэвээр нь хадгална;
- Одоогийн байгаа хамгаалах газрын хүрээг багасгахгүй байх;
- Одоогийн байгаа хамгаалалтын газрын чанар, үр өгөөжийг бууруулахгүй байх;
- Экологийн эмзэг, экологийн доройтолд орсон газрыг нөхөн сэргээх;

7.8 Амралт зугаалгын ногоон байгууламжийг буй болгохдоо байгалийн үзэмж, түүх соёлын дурсгалт газрын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтэц зэргийг харгалзах.

7.9 Дүүргийн ногоон байгууламжийн хөгжлийн стратеги төлөвлөлтөд 1 хүнд ногдох талбайн хэмжээ 10м^2 -аас багагүй байна.

7.10 Амралт зугаалгын ногоон байгууламжийн нэг хүнд ноогдох талбайг тооцохдоо тус зөвлөмжийн А.2 томьёоллоор тооцно.

7.11 Хотын замын системийн төлөвлөлт нь байгалийн элементэд суурилж түүхэн дурсгалт болон аялал жуулчлалын амралтын газар, тариалангийн бүс, онцлох сум орон нутаг зэрэг хот хөдөөгийн жуулчлалын орон зайг холбож экологийн хамгаалалтын чадамжтай ногоон коридорыг байгуулах.

7.12 Ойн цэцэрлэгт хүрээлэнг төлөвлөхдөө ой шугуйн унаган дүр төрхийг хамгаалж нэгж талбай нь $500\ 000\text{м}^2$ -аас их байхаар тооцно.

7.13 Нуга газрын цэцэрлэгт хүрээлэнг төлөвлөхдөө экологийн системийн бүрэн бүтэн байдал болон биологийн олон янз байдлыг хамгаална.

- Хотын нуга газрын цэцэрлэгт хүрээлэнгийн талбай нь $100\ 000\text{м}^2$ -аас их байхаар тооцно.
- Нуга газрын талбай нь нийт цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн 50%-аас багагүй байна.
- Шинжлэх ухаан, аялал жуулчлал зэрэг ерөнхий зүйлүүдийг анхаарч, хамгаалалт болон нөхөн сэргээхэд чиглэсэн төлөвлөлттэй байх.



Зураг 7.2 Нуга газрын цэцэрлэгт хүрээлэн

7.14 Дүүргийн хэмжээний цэцэрлэгт хүрээлэнг төлөвлөхдөө нийтийн тээврийн үйлчилгээ болон байгалийн онцлогийг анхаарч биологийн олон хэлбэрт чанарыг хамгаалан доорх стандартад нийцүүлнэ:

- Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн нэгж хэмжээ нь $100\ 000\text{м}^2$ -аас их байхаар тооцно;
- Аялал зугаалга болон боловсролын байгууллагад ашиглах том хэмжээний барилга байгууламжийг төлөвлөхгүй байх;

7.15 Үйлдвэрийн ногоон байгууламжийн төлөвлөлтийн талбай нь 20% байх ёстой.

7.16 Хотын экологийг их хэмжээгээр бохирдуулагч үйлдвэрүүдийн ногоон байгууламж 30%-аас багагүй байх.

7.17 Хотын хэмжээний төмөр зам болон засмал замын хажууг хамгаалан тусгаарлах ногоон бүсийг байгуулах.

7.18 Дүүргийн ногоон байгууламжийн системийн төлөвлөлт нь доорх зүйд нийцсэн байх:

- Дүүргийн газарзүйн онцлогт тохируулан экологийн орон зайг организмаар уялдуулна;
- Тухайн дүүргийн газар зүйн онцлогт тохируулан уул ус болон түүх соёлын эх баялгийг хамгаална;
- Дүүргийн хил хязгаар, байршил ба дизайны онцлогийг харилцан зохицуулна;

7.19 Дүүргийн хэмжээний газар нутгийг ашиглалтаас нь хамааран хэсэгчлэн ногоон бүсээр тусгаарлана.

7.20 Цэцэрлэгт хүрээлэнгийн системийг төрөл бүрийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон бүсийг үе шаттайгаар тохижуулах зарчмыг баримтлан байршлыг тэнцвэртэй болгож, төрөл хэлбэрийг баяжуулан дизайны онцлогийг тусгана. Сүлжээг доорх дүрэмд нийцүүлнэ.

- Дүүргийн шинэчлэлтэд уялдуулан ногоон байгууламжийг тэнцвэртэй байгуулж, үйлчилгээг дээшлүүлнэ;
- Үйлчилгээний түвшинд тохируулан цэцэрлэгийн ногоон байгууламжийн хэмжээг өөр өөр хувилбараар төлөвлөнө;
- Хүүхдийн тоглоомын талбай, ургамлын, спортын, аялал амралтын болон амьтны хүрээлэн зэрэг олон төрлийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна;
- Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг тухайн газар нутгийн соёлын онцлогоор сэдэвлэн тохижуулна;

7.21 500м үйлчилгээний хэсэг ба орон сууцад ашиглах талбайг тооцоолох арга нь тус баримт бичгийн А.3 томьёололд нийцсэн байна.

7.22 Эрүүл ахуй, аюулгүй байдал, экологийн хамгаалалтын шаардлагаар дүүргийн ногоон байгууламжийг хамгаалах бүсийг буй болгоно.

- Байгалийн хүчин зүйлсийн эрсдэлийг тооцож байгуулна;
- Хотын төв цэвэрлэх байгууламж, хогийн цэг, ус цэвэршүүлэх байгууламж, чандарлах газар зэргийг хотоос гадна байгуулна;
- Үйлдвэр, зах, утаа, хорт хий зэргийг ялгаруулдаг аж үйлдвэрийн бүсийг хотоос гадна байгуулах;
- Гол мөрөн, нуур цөөрөм, хурдны зам ба төмөр зам дагуу байгуулна;
- Газар доорх шугам хоолой болон өндөр хүчдэлийн шугам дагуу станцын гадна байрлуулна;

8. ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ

8.1 Нэг хүнд ноогдох цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн ашиглах талбайг төлөвлөж, талбайн харьцааг боловсруулан дагаж мөрдөнө.

8.2 Дүүргийн нэг хүнд ноогдох цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж нь 7.0 м²-аас багагүй байна.

8.3 Төлөвлөж буй хот суурин газрын ногоон байгууламжийн үзүүлэлт нь 35% -аас багагүй, дүүрэгт төлөвлөсөн ногоон байгууламжийн хэмжээ 28% -аас багагүй байна.

8.4 10 000 хүн тутамд төлөвлөсөн цогц цэцэрлэгт хүрээлэнгийн үзүүлэлт 0.06-аас багагүй байх бөгөөд 10 000 хүнд ногдох цогц цэцэрлэгт хүрээлэнгийн үзүүлэлтийг тооцоолох арга нь энэ удирдамжийн А.4-т нийцсэн байна.

8.5 Орон сууцны хорооллын цэцэрлэгт хүрээлэнг хэмжээнээс нь хамааруулж 2 хэлбэрээр зохион байгуулна. Үүнд: Цэцэрлэгт хүрээлэн (дүүргийн хэмжээний жижиг цэцэрлэг, зориулалт бүрээр хэсэгчилсэн, байгууламжаар тоноглогдсон), Амралт зугаалгын цэцэрлэг (бага хэмжээтэй, оршин суугчид зөвхөн алхах, амрахад зориулагдсан).

8.6 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн төлөвлөлт нь Хүснэгт 8.1-ийн шаардлагыг хангасан байна. Ижил төрлийн, өөр өөр хэмжээтэй цэцэрлэгт хүрээлэнг үйлчилгээний радиусын дагуу янз бүрийн түвшинд, тэнцвэртэй зохион байгуулалттай байгуулах ёстой бөгөөд барилга байгууламжийг нэгтгэн орлуулж болохгүй.

Хүснэгт 8.1 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн ангилалд тавигдах шаардлага

Ангилал		Хүн амд хүрэлцэх хэмжээ (10000 хүн)	Үйлчилгээн ий радиус (м)	Тохиромжт ой хэмжээ (га)	Ногдох үзүүлэлт М2/хүн	Тайлбар (ногоон байгууламжийн хэмжээ)
Цогц цэцэрлэгт хүрээлэн		>50.0	>3000	≥50.0	≥1.0	50000м2-аас багагүй байна.
		20.0~50.0	2000~3000	20.0~50.0	1.0~3.0	20000м2-аас багагүй байна.
		10.0~20.0	1200~2000	10.0~20.0	1.0~3.0	10000м2-аас багагүй байна.
Орон сууцны цэцэрлэгт хүрээлэн	Цэцэрлэгт хүрээлэн	5.0~10.0	800~1000	5.0~10.0	≥2.0	50000м2-аас багагүй байна.
		1.5~2.5	500	1.0~5.0	≥1.0	10000м2-аас багагүй байна.
	Амралт зугаалгын цэцэрлэг	0.5~1.2	300	0.4~1.0	≥1.0	нь 4000м2-аас багагүй байна.
		-	300	0.2~0.4	-	-

Тайлбар: 1. Хуучин хотод 2500м²~5000м² -ийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж нь үйлчилгээний радиусын хүрээг 300м-ийн дагуу тооцох бөгөөд түүх ба соёлын гудамжийг 1000м² болгон бууруулж болно.

8.8 Жижиг хотууд болон дунд хотуудын нэг хүнд ногдох төрөлжсөн цэцэрлэгт

хүрээлэнгийн талбай 1.0м^2 -ээс багагүй байна.

8.9 Том хотууд болон томоохон хотуудад нэг хүнд ногдох төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэнгийн талбай 1.5м^2 -ээс багагүй байх ёстой.

8.10 Ботаникийн цэцэрлэгийг хот, дүүрэг, аймгийн төвүүдэд байгуулах; Ботаникийн цэцэрлэгүүдийн онцлог, шинж чанарыг цаг уур, газарзүй, ургамлын нөөцийн нөхцөлөөс хамааруулан тодорхойлж байгуулах.

8.11 Хот, дүүргийн эдэлбэр газруудад том, дунд хэмжээний амьтны хүрээлэн байгуулах;

- Хотуудын цогцолборт газруудад тусгай амьтны хүрээлэн, амьтдыг үзэх үзвэрийн газар байгуулах;
- Боломжит хотуудад зэрлэг амьтны хүрээлэн байгуулах;

8.12 Томоохон хот, аймаг, сум, дүүргүүдэд хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

A.1 Ногоон байгууламжийн харьцааг тооцоолох аргыг дараах байдлаар тооцно:

$$\text{Ногоон байгууламжийн хэмжээ} = \frac{\text{Эдэлбэр газар дахь төрөл бүрийн ногоон байгууламжийн нийт талбайн хэмжээ}}{\text{Эдэлбэр газар дахь ерөнхий талбайн хэмжээ}} \quad (\text{A.1})$$

A.2 Төлөвлөж буй хотын нэг хүнд ногдох үзэсгэлэнт газар, амралт чөлөөт цагийн ногоон байгууламжийг тооцоолох арга.

$$\text{Нэг хүнд ногдох үзэсгэлэнт ба амралт чөлөөт цагийн ногоон байгууламж} = \frac{\text{Хотын үзэсгэлэнт ба амралт чөлөөт цагийн ногоон байгууламж (м}^2\text{)}}{\text{Хотын төлөвлөсөн хүн ам (хүн)}} \quad (\text{A.2})$$

Тайлбар: Хотын төлөвлөгөөт хүн амыг зөвхөн хотын төвийн хүн ам биш, хотын хүрээнд төлөвлөсөн нийт хүн амыг оруулна.

A.3 Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн үйлчилгээний радиус 500 м-т хамаарах орон сууцны талбайн эзлэх хувийг дараах байдлаар тооцож болно:

$$\text{Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн үйлчилгээний радиусын хамрагдах хувь хэмжээ} = \frac{\text{Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн радиусын ОС хорооллын эдэлбэр газрын хэмжээ (га)}}{\text{Орон сууцны хорооллын эдэлбэр газрын нийт талбайн хэмжээ (га)}} \times 100\% \quad (\text{A.3})$$

Тайлбар: Энэхүү стандартад заасан “Хотын цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж ба талбайн газрын үйлчилгээний радиусын 500 м-ийн харьцаа” -г “Хотын цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж ба талбайн газрын 500 м-ийн үйлчилгээний радиусаар бүрхэгдсэн орон сууцны талбайн хэмжээ” -ний хуваагчаар солих нь зүйтэй.

А.4 10000 хүнд ногдох цогц цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий үзүүлэлтийг тооцоолох арга:

$$10000 \text{ хүнд ногдох цогц цэцэрлэгт} = \frac{\text{Цогц цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий тоо (ш)}}{\text{Статистик тоо (10000 хүн)}} \quad (\text{А.4})$$

9. ХОТ СУУРИН ГАЗРЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ногоон байгууламжийн ангиллыг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04- д заасан үндсэн 3 ангиллыг үндэслэн хотын эдэлбэр газар доторх ногоон байгууламжийг ангилсан бөгөөд Олон улсын ангиллын системийг үндэслэн хотын гаднах ногоон байгууламж зэргээр ангилав (Хятад улсын “Хотын ногоон байгууламжийн ангиллын стандарт” CJJ / Т 85-2017). Ногоон байгууламжийг ангилахдаа дараах дүрмийг баримтлан ангилсан болно. Үүнд:

- Ногоон байгууламжийг гол зориулалтаар ангилах.
- Ногоон байгууламжийн ангилалд том, дунд, жижиг гэсэн гурван түвшинд ангилан ашиглах
- Ногоон байгууламжийн ангилалд монгол үсэг болон араб тооны нийлэмжийн илэрхийллийг ашиглах (хүснэгт 9.1).

Хотын доторх ногоон байгууламжийг 3 том ангилал, 14 дунд ангилал, 23 жижиг ангилалд ангилав. Харин хотын гаднах ногоон байгууламжийг 1 том, 4 дунд, 5 жижиг ангилалд хувааж үзэв.

Хүснэгт 9.1. Ногоон байгууламжийн ангиллын тайлбар

№	Ангилал	Жишээ	Код
Эхний том үсэг нь	Хотын доторх ногоон байгууламжийн ерөнхий ангилал	Нийтийн зориулалттай ногоон байгууламж	Н
		Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж	Х
		Тусгай зориулалттай ногоон байгууламж	Т
	Хотын гаднах ногоон байгууламжийн ерөнхий ангилал	Байгалийн үзэмжит амралтын ногоон байгууламж	Б
2 дахь араб тоо	Дунд ангилал	Цэцэрлэгт хүрээлэн	Н1
3 дахь араб тоо	Жижиг ангилал	Цогц цэцэрлэгт хүрээлэн	Н11

9.1. ХОТ СУУРИН ГАЗРЫН ДОТОРХ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

Хот суурин газрын доторх ногоон байгууламжийн ангиллыг хүснэгт 9.2, хүснэгт 9.3, хүснэгт 9.4, хот суурин газрын гаднах ногоон байгууламжийн ангиллыг хүснэгт 9.5-д тус тус санал болгов.

Нийтийн зориулалттай ногоон байгууламж нь амралтын төрөл бүрийн хэлбэрт зориулагдсан ногоон байгууламж юм. Хотын нийт оршин суугчид болон амрагчдыг богино, урт хугацаагаар амрах, бие бялдрын боловсрол, спорт, соёл урлаг, зугаа цэнгэлийн арга хэмжээг зохион байгуулах боломжтой газар юм.

Энэхүү нийтийн зориулалттай ногоон байгууламжийн том ангилалд 6 дунд ангилал, 16-н жижиг ангилалд хуваав. Үүнд:

1. Цогц цэцэрлэгт хүрээлэн (Н1)
2. Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн (Н2)
3. Орон сууцны хорооллын ногоон байгууламж (Н3)
4. Цэцэрлэгт гудамж (Н4)
5. Цэцэрлэгжүүлсэн талбай (Н5)
6. Байгалийн ногоон бүс (Н6)

Хүснэгт 9.2. Нийтийн зориулалттай ногоон байгууламжийн ангилал

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1	Н			Нийтийн зориулалттай ногоон байгууламж	Амралтын янз бүрийн хэлбэрт зориулагдан тохижуулсан талбай.	
1.1		Н1		Цогц цэцэрлэгт хүрээлэн	Төрөл бүрийн гадаад үйл ажиллагаа зохион байгуулахад тохиромжтой, амрах болон үйлчилгээний байгууламж сайтай ногоон байгууламж	Талбайн хэмжээ 100 000м ² -аас их
1.1.1			Н11	Хотхоны цэцэрлэгт	Ашиглах газар бие даасан. Амрах болон	Талбайн хэмжээ 10

				хүрээлэн	үйлчилгээний үндсэн байгууламжтай, тодорхой хотхоны хүрээний оршин суугчдын өдөр тутмын амралтын арга хэмжээ зохион байгуулахад дөхөм ногоон байгууламж байх.	000м ² -аас их байх
1.2		H2		Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн	Тусгай тогтсон агуулга эсвэл хэлбэртэй, амрах болон үйлчилгээний зохистой байгууламжтай ногоон байгууламж	
1.2.1			H21	Ургамлын цэцэрлэгт хүрээлэн	Ургамлын шинжлэх ухааны судалгаа, нутагшуулах, ургамал хамгаалал, үзмэр, амралт, шинжлэх ухаан түгээх зэрэг арга хэмжээгээр хангах, байгууламж, тайлбар тэмдэглэл сайтай системтэй ногоон байгууламж	
1.2.2			H22	Амьтны цэцэрлэгт хүрээлэн	Тэжээвэр нөхцөлд шилжүүлсэн зэрлэг амьтдыг хамгаалах, тэжээж, үржүүлэх зэрэг шинжлэх ухааны судалгаа хийх, түгээх, үзэж сонирхох, амрах зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн байгууламж бүхий цэцэрлэг	
1.2.3			H23	Түүхэн цэцэрлэгт хүрээлэн	Тодорхой түүхийн үеийн төлөөллийг тусгасан цэцэрлэгийн урлаг, тусгай хамгаалалт хэрэгтэй цэцэрлэг	
1.2.4			H24	Туурийн цэцэрлэгт хүрээлэн	Чухал туурь болон түүнд тулгуурлаж бий болсон, туурийн хамгаалал, үзмэр зэргийн тал дээр дуурайлал болохуйц ач холбогдолтой, мөн соёл, амралтын зэрэг үүрэг ажиллагаатай ногоон байгууламж.	Түүхийн дурсгалыг хамгаалах, экологийн орчныг сайжруулах, аялал, жуулчлалтай уялдуулан төлөвлөснөөрөө онцлог
1.2.5			H25	Тоглоомын цэцэрлэгт хүрээлэн	Томоохон хэмжээний тоглоомын байгууламжтай, экологийн орчин харьцангуй сайтай ногоон байгууламж	Ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээ 65%-тай тэнцэх эсвэл их байх.
1.2.6			H26	Бусад төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн	Биеийн тамир бялдаржуулах, усан болон хотын эдэлбэр газарт байрлах байгалийн цэцэрлэгт	Ногоон байгууламжийн эзлэх хэмжээ 60%-аас

					хүрээлэн, намгархаг болон ойн цэцэрлэгт хүрээлэнг багтааж болно.	дээш байна.
1.3		Н3		Орон сууцны хорооллын ногоон байгууламж	Амрах болон үйлчилгээний үндсэн байгууламжтай, тодорхой хүрээний оршин суугчдын өдөр тутмын амралтын арга хэмжээ зохион байгуулахад дөхөм ногоон байгууламж юм.	10000м ² –аас их, хорооллын оршин суугчдад зориулагдсан.
1.3.1			Н31	Нийтийн орон сууцны ногоон байгууламж	Оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах, амрах, үйлчлүүлэхэд зориулагдсан ногоон байгууламж юм.	Өндөр давхрын орон сууцны хорооллууд хамаарна.
1.3.2			Н32	Амины орон сууцны ногоон байгууламж	Амины сууцны эдэлбэр газарт хүүхдийн тоглоомын талбай, спортын тоног төхөөрөмжтэй талбай, амралтын талбайн ногоон байгууламж юм.	Амины эдэлбэр газартай орон сууцны ногоон байгууламж, инженерийн хангамжтай орон сууцны ногоон байгууламж байна.
1.4		Н4		Цэцэрлэгт гудамж	Авто зам дагуу тохижуулсан нийтийн эзэмшлийн талбай, явган хүний дамжин өнгөрөх хөдөлгөөн, богино хугацааны амралтад зориулагдсан янз бүрийн өргөнтэй зурвас хэлбэртэй ногоон байгууламж юм.	2 талаараа автозамаар хязгаарлагдсан өргөн (18-50м) чөлөө юм.
1.4.1			Н41	Цуваа цэцэрлэг	Хот суурин газрын замыг салхи шуурга, ус цасны нөлөөгөөр элэгдэж, эвдрэхээс хамгаалах, явган замыг машин замаас тусгаарлах, барилгын нүүр, ханыг чимэглэж хөшиг болгон ашигладаг ногоон байгууламж юм.	Авто замын дагуу мод, сөөг цувуулан суулгасан ногоон байгууламжийн хэлбэр юм.
1.4.2			Н42	Гудамж, зам талбайн ногоон байгууламж	Явган зорчигч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, түр амрахад зориулагдсан ногоон байгууламж юм.	Гэр хорооллын сууц бүхий суурьшил дах гудамж, зам талбайн ногоон байгууламж хамаарна.
1.4.3			Н43	Тусгаарлах зурвас	Гудамж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны	Мод, сөөгөөр

					буудлын зурвас газар, үйлдвэрлэлийн бүс, хог хаягдлын цэг, оршуулгын газар зэрэг тусгай зориулалтын үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжийг олон нийт, орон сууцны бүсээс тусгаарлах ногоон байгууламж юм	тусгаарлах, хамгаалах зориулалттай ногоон зурвас юм.
1.5		H5		Цэцэрлэгжүүлсэн талбай	3 га хүртэлх талбай бүхий орон сууцны хорооллын амралт зугаалгын, спорт, амралт, тоглоомын байгууламжаар хангасан нийтийн хэрэгцээний цэцэрлэгжүүлсэн талбайн юм.	Талбайн зохион байгуулалтын хувьд зам, тоглоомын талбай, зүлэг, цэцгийн мандал, мод сөөгний бүлэглэлийг багтаана.
1.5.1			H51	Бичил цэцэрлэг	1 га хүртэлх хэмжээтэй, богино хугацааны амралт, явган хүний дамжин өнгөрөх хөдөлгөөнд ашиглагдах бичил цэцэрлэг юм.	Нэг төрлийн агуулгаар тохижуулагдсан бичил талбайнууд хамаарагдана.
1.5.2			H52	Дээврийн цэцэрлэг	Дээврийн цэцэрлэг нь барилга байгууламжийн дээвэр дээрх орчныг тохижуулж, агаарыг цэвэршүүлж, бичил уур амьсгалыг сайжруулахаас гадна хотын ногоон бүрхүүлийг нэмэгдүүлэх боломжтой ногоон байгууламж юм.	Цэцэрлэгжүүлэх боломжтой барилга байгууламжийн дээврийн талбай хамаарна.
1.6		H6		Байгалийн ногоон бүс	Байгалийн унаган төрхөд түшиглэн иргэдийн амралт зугаалга, аялал жуулчлалын зориулалтаар ашиглах бүс нутагт байгуулсан ногоон байгууламж юм.	
1.6.1			H61	Голын ай сав	Хот суурин газрыг дамжин өнгөрдөг голын ай сав дагуу амрагч, аялагчдад зориулагдсан ногоон байгууламж юм.	Хотыг дамжин өнгөрдөг голын ай, сав газрууд хамаарна.
1.6.2			H62	Уулын ландшафт	Уулын ландшафтын онцлог байдлыг харгалзан хотыг тольдох өндөрлөг, амралт, аялал зугаалгын зориулалтаар тохижуулсан ногоон байгууламж юм.	Уулын ногоон бүс хамаарна.

Тухайн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийг байгуулдаг. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжид хүүхдийн цэцэрлэг, спорт, соёл, боловсролын байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд хамаардаг. Эдгээр газруудын ногоон байгууламжид дасгал

хийх, спортоор хичээллэх, хүүхдүүдэд зориулан тоноглох, эмчилгээ сувилал болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, ажлын хооронд амрах зориулалттайгаар төлөвлөгддөг.

Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийг ахуйн нэгж, байгууллагын ажилчид, сурагчид, оюутнууд, өвчтөнүүд, эрүүл мэндийн байгууллагуудад зочлогсод ашигладаг. Энэхүү ногоон байгууламжийн 3-н дунд ангилал, 8-н жижиг ангилалд хуваав.Үүнд:

1. Сургуулийн ногоон байгууламж (Х1)
2. Эмнэлэг, сувиллын газрын ногоон байгууламж (Х2)
3. Дагалдах ногоон байгууламж (Х3)

Хүснэгт 9.3. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн ангилал

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1	Х	Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж			Эмнэлгийн, хүүхдийн боловсрол, шинжлэх ухааны байгууллагууд, аж үйлдвэрийн газрууд гэх мэт хамаарагдана.	
1.1		X1		Сургуулийн ногоон байгууламж	Сургуулийн эдэлбэр газарт хүүхдийн боловсрол, танин мэдэхүй, амрах, аюулгүй байдлыг хангасан ногоон байгууламж юм.	
1.1.1			X11	Их сургуулийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Коллеж, их дээд сургуулийн багш, суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэн орон зайн хэлбэр, ургамлын хослол зэргээр орчны ая тухтай байдлыг бүрдүүлэх юм.	Сурч боловсроход таатай орчин бүрдүүлэхэд зориулагдсан ногоон байгууламжууд хамаарна.
1.1.2			X12	Ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Сургуулийн орчны ногоон байгууламжийн онцлог хүмүүнлэг, мэдлэг боловсрол суурилсан ландшафт бүхий орчинг бүрдүүлж, сурагчдын ёс суртахууны чанарыг сайжруулах, бие даан суралцах урам зоригийг идэвхжүүлэх, биологийн практик хичээлийг хэрэгжүүлэхэд кампусын ургамлын нөөцийг ашиглах зэрэг өндөр ач холбогдолтой.	
1.1.3			X13	Хүүхдийн цэцэрлэгийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Цэцэрлэгийн орчныг ногооруулах ажлыг шинжлэх ухаан, оновчтой, аюулгүй байдал хангасан хүүхдийн өсөлт хөгжил, танин мэдэхүйд	

					зориулсан ногоон байгууламж байна.	байгууламж хамаарна.
1.2		X2		Эмнэлэг, сувиллын ногоон газрын байгууламж	Эмнэлэг нь янз бүрийн хэрэглээний шаардлага бүхий хэсгүүдээс бүрдэх бөгөөд ерөнхий төлөвлөлт функциональ шаардлагын дагуу хийгддэг. Тухайлбал эмчилгээний, ерөнхий хэсгүүдэд хувааж амбулаторийн, хэвтэн эмчлүүлэх, туслах хэсгүүд зэрэгт хуваан тохижуулна.	Эмнэлэг, сувиллын үйлчилгээний зориулалтаас хамааран цэцэрлэгжүүлсэн эдэлбэр газрууд хамаарна.
		X3		Дагалдах ногоон байгууламж	Аж ахуйн үйл ажиллагааны зориулалттай байгууламжийг хэлнэ.	төрөл бүрийн ногоон
1.3			X31	Аж ахуй нэгж, байгууллагын эдэлбэр газрын ногоон байгууламж	Аж ахуй нэгж, байгууллагуудад хамааралтай эдэлбэр газрын орчныг ландшафтыг сайжруулах, хамгаалахад анхаарч, тохижилт, гоёл чимэглэлийн чиг үүрэгтэй ногоон байгууламж юм. Талбайн байршлаас хамааруулан өнгө, үзэмж сайтайгаар төлөвлөх.	Төрийн болон хувийн өмчит байгууллагын эдэлбэр газар дах ногоон байгууламжууд хамаарна.
1.4			X32	Үйлдвэрийн зориулалттай эдэлбэр газрын ногоон байгууламж	Үйлдвэрийн ногоон байгууламж нь тоос шороо, дуу чимээг бууруулах, үйлдвэрийн орчны зохих үр нөлөөг бууруулахыг шаарддаг. Мөн үйлдвэрийн онцлог, хэв маягийг бүрэн илэрхийлэх ногоон байгууламж байна.	Үйлдвэрлэл явуулж байгаа байгууллагуудын эдэлбэр газрын ногоон байгууламж хамаарна.
1.5			X33	Худалдаа, үйлчилгээний зориулалттай эдэлбэр газрын ногоон байгууламж	Худалдаа, үйлчилгээний зориулалттай ногоон байгууламж нь үйлчлүүлэгчдийн анхаарлыг татах, аюулгүй байдлыг хангах, гоёл чимэглэлийн чиг үүрэгтэйгээр төлөвлөсөн ногоон байгууламж юм.	Том, жижиг бүх худалдааны төвийн эдэлбэр газар дах ногоон байгууламж хамаарна.
1.6			X34	Логистик хадгалалтын газрын ногоон байгууламж	Логистик хадгалалтын эдэлбэр газрын ногоон байгууламж юм.	Логистикийн үйл ажиллагаа эрхэлж байгаа газрууд хамаарна.
1.7			X35	Авто замын дагуух ногоон байгууламж	Авто замын дагуух ногоон байгууламж нь авто машинаас ялгарах утаа тортог, дуу чимээг шингээх, хэт халалтыг бууруулах, явган хүнээс тусгаарлах зориулалттай.	Авто замын сүлжээ дагуух ногоон байгууламж хамаарна.

Тусгай зориулалтын ногоон байгууламжийг аж үйлдвэр, тээврийн салбарын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг

бууруулах зорилгоор ашигладаг. Зорилгоос хамааран (бохирдол, салхи, цас, элсний шуурганаас хамгаалах; гал, утаа, дуу чимээ, үерийн тархалтад саад бий болгох; усан сангийн ууршилтыг бууруулах гэх мэт), байршил, дизайн, ургамлын төрөл зүйлийг сонгоно.

Тусгай зориулалттай ногоон байгууламжийн ангилалд хамгаалалтын ногоон байгууламж, хамгаалалтын ойн бүс, ундны усны эх үүсвэрийг хамгаалах, оршуулгын газар зэргийн хамруулан ойлгоно. Энэхүү ангиллыг 2 дунд ангилал, 2 жижиг ангилалд хуваав. Үүнд:

1. Хамгаалалтын ногоон байгууламж (Т1)
2. Оршуулгын газар (Т2)

Хүснэгт 9.4. Тусгай зориулалттай ногоон байгууламжийн ангилал

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1	Т	Тусгай зориулалттай ногоон байгууламжийн төлөвлөлт			Ариун цэвэр, усны эх үүсвэрийн хамгаалалт, хамгаалалт-нөхөн сэргээлт, гал түймрээс урьдчилан сэргийлэх бүс, оршуулгын газар зэрэг багтана.	
1.1		T1		Хамгаалалтын ногоон байгууламж	Эрүүл ахуй, хөл хорих, аюулгүй байдал, экологийг хамгаалах үүрэгтэй, зорчигч ногоон байгууламж руу орж болохгүй.	
1.1.1			T11	Хамгаалалтын ойн зурвас (Ногоон зурвас)	Салхины хамгаалалт, элсний нүүлт, тариалангийн талбайн хамгаалалт, бэлчээрийн хамгаалалт, эргийн хамгаалалт, бохирдлоос урьдчилан сэргийлэх, зам болон төмөр замаас хамгаалах, өндөр хүчдэлийн шугамаас хамгаалах ногоон байгууламж болон нийтийн хэрэгцээний байгууламжийг хамгаалах ногоон байгууламж зэрэг багтана.	Хамгаалалтын ойн зурвас хийх шаардлагатай бүс хэсгүүд хамаарна.
1.1.2			T12	Усны эх үүсвэрийг хамгаалах ногоон байгууламж	Хэт их ашиглалт, бохирдлоос сэргийлэхийн тулд усны эх үүсвэрийг хамгаалах ногоон байгууламж юм.	Голын эх, булаг, шанд болон усны эх үүсвэрийн ландшафтыг зориудаар хамгаалсан ногоон байгууламж хамаарна.
1.2		T2		Оршуулгын газрын ногоон байгууламж	Чимээгүй хотын эдэлбэр газрын орчны бохирдлыг багасгах, байгаль экологид эергээр нөлөөлөх ногоон байгууламжийн төлөвлөлт юм.	Бүх төрлийн чимээгүй хотын ногоон байгууламжууд хамаарна.

9.2 ХОТ СУУРИН ГАЗРЫН ГАДНАХ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

Орчин үеийн хотын ногоон байгууламжийн системийг хүрээлэн буй орчныг сайжруулах, хотын гадаад үзэмжийг баяжуулах, байгалийн орчинд хүн амын амралт, зугаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор буй болгосон ногоон байгууламж юм. Хот суурин газрын гаднах ногоон байгууламжийг 4 дунд бүлэг, 5-н жижиг ангилалд хуваав. Үүнд:

1. Байгалийн үзэмжит амралтын газрын ногоон байгууламж (Б1)
2. Экологийн хамгаалалтын ногоон байгууламж (Б2)
3. Бүс нутгийн хамгаалалтын ногоон байгууламж (Б3)
4. Үржүүлгийн газрын ногоон байгууламж (Б4)

Хүснэгт 9.5 Хот суурин газрын гаднах ногоон байгууламжийн ангилал

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1				Байгалийн үзэмжит газрын ногоон байгууламж	Хот байгуулалтын зориулалт бүхий газраас бусад газар байрлаж хот, хөдөөгийн экологийн орчин, байгалийн ба соёлын нөөцийг хамгаалах, амралт чийрэгжүүлэлт, аюулгүй байдлаас хамгаалан тусгаарлах, ургамлын төрөл зүйлийн хамгаалалт, цэцэрлэгт нахиалах модны үйлдвэрлэл гэх мэт чиг үүрэгтэй ногоон байгууламж.	Хотын эдэлбэр газар доторх хамаарахгүй.
1.1		Б1		Байгалийн үзэмжит амралтын газрын ногоон байгууламж	Байгалийн орчин нөхцөл сайтай, олон нийтэд нээлттэй бөгөөд амралт, чөлөөт цаг, аялал жуулчлал, үзвэр үйлчилгээ, спорт, шинжлэх ухааны хайгуул зэргээр үндсэн чиг үүрэг болгосон амралт ба үйлчилгээний ногоон байгууламж	Бүх төрлийн амралтын газрын ногоон байгууламж хамаарна.
1.1.1			Б11	Байгалийн дурсгалт газар	Холбогдох эрх бүхий хэлтсийн зөвшөөрлөөр байгуулагдсан бөгөөд үзмэр, соёл, шинжлэх ухааны үнэ цэнтэй, байгалийн болон соёлын үзэмж	Байгалийн үзэмжтэй, амарч зугаалахад тохиромжтой газар

	Б				харьцангуй төвлөрсөн, орчин нь гоёмсог, хүмүүс аялж амрах эсвэл шинжлэх ухаан, соёлын үйл ажиллагаа эрхэлж болох газар.	нутаг хамаарна.
1.1.2			Б12	Ойн цэцэрлэг	Энэ нь тодорхой хэмжээний цар хүрээтэй, үзэсгэлэнт ойн бүс бөгөөд хүмүүсийн зугаалах, эсвэл шинжлэх ухаан, соёл, боловсролын үйл ажиллагаа эрхлэх боломж бүхий ногоон байгууламж юм.	Амарч зугаалах орчин бүрдүүлсэн ойн цэцэрлэгүүд хамаарна.
1.1.3			Б13	Намгархаг газрын цэцэрлэг	Үзэмжит намгархаг газрын экологийн орчин болон төрөлжүүлсэн намгархаг газрын өнгө үзэмжийн нөөцөд тулгуурлан экологийг хамгаалах, шинжлэх ухааны боловсрол, намгархаг газрын судалгаа, экологийн чөлөөт цаг зэрэг олон төрлийн үйл ажиллагааг багтаасан амралт, үйлчилгээ бүхий ногоон байгууламж.	Амарч, зугаалахад тохиромжтой, тохилог орчин бүрдүүлсэн газрууд хамаарагдана.
1.1.4			Б14	Алслагдсан бүсийн байгалийн цэцэрлэгт хүрээлэн	Хотын захад байрладаг, тодорхой цар хүрээтэй, голчлон хөдөөгийн байгалийн өнгө үзэмжтэй, байгальд ойр байх, амралт, чөлөөт цаг, байгалийн ухааны боловсрол зэрэг үйл ажиллагаатай үйлчилгээний байгууламж бүхий ногоон байгууламж.	Хотын захын байгалийн цэцэрлэгт хүрээлэнгүүд хамаарна.
1.1.5			Б15	Бусад байгалийн үзэмж, аялал жуулчлалын ногоон байгууламж	Дээр дурдсан үзэсгэлэнт, амралт зугаалга бүхий ногоон байгууламжаас гадна зэрлэг ан амьтдын цэцэрлэгт хүрээлэн, археологийн цэцэрлэгт хүрээлэн, геологийн цэцэрлэгт хүрээлэн гэх мэт орно.	
1.2		Б2		Экологийн хамгаалалтын ногоон байгууламж	Хот, хөдөөгийн экологийн аюулгүй байдлыг хангах, өнгө үзэмжийн чанарыг сайжруулан хамгаалах нөхөн сэргээх эх үүсвэрийг хамгаалах ногоон байгууламж. Байгалийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийг хамгаалах бүс, намгархаг газрыг хамгаалах бүс, нийтийн эзэмшлийн ой, ус хамгаалах ой, экологийн нөхөн сэргээлт хийх талбай, биологийн зүйлийн амьдрах орчин зэрэг олон төрлийн экологийг	

					хамгаалах чиг үүрэг бүхий ногоон байгууламж.	
1.3		Б3		Бүс нутгийн хамгаалалтын ногоон байгууламж	Бүс нутгийн тээврийн байгууламж, бүс нутгийн нийтийн байгууламж гэх мэт эргэн тойрны аюулгүй байдал, хамгаалалт, ариун цэвэр, тусгаарлах функц бүхий ногоон бүс. Үүнд голдуу бүх түвшний авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах өөрчлөх байгууламж, хүрээлэн буй орчны ариун цэврийн байгууламж зэрэг хүрээлэн буй орчныг хамгаалах, тусгаарлах ногоон байгууламжийн газар ашиглалт.	Бүс нутгийн байгууламж гэдэг нь хотын барилга байгууламжид ашиглахаас бусад байгууламж юм.
1.4		Б4		Үржүүлгийн газрын ногоон байгууламж	Хот суурин газрын ногоон байгууламж, тохижилтын ажилд зориулсан төрөл бүрийн суулгац, цэцэг, үр үржүүлгийн газар, цэцгийн мандал, зүлэг зэрэг үржүүлгийн газар.	Үржүүлгийн газрууд хамаарна.

9.3 ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙГ БҮРДҮҮЛЭГЧ НЭГЖ ЭЛЕМЕНТУҮД

Хот суурин газрын ногоон байгууламжийг байгуулахад ангиллын зориулалтын шаардлага хангасан орчныг бүрдүүлэх, түүнийг цэцэрлэгжүүлэх, тохижуулахад тусгай нэгж элементүүдээс бүрддэг.

Нэгж элементүүд нь цэцэрлэгжүүлэх газрын байршил, зориулалт, зорилготой уялдуулан зохиомжилж, аюулгүй орчин нөхцөл үүсгэхэд тавигдах шаардлагыг ханган ашиглагдаж, зохицуулагдана. Эдгээр нэгж элементүүдийг ногоон байгууламжийн үндсэн элементүүд, архитектурын бага хэлбэрүүд, цэцэрлэгжүүлэлтийн зам, талбайн хучилтууд болон цэцэрлэгжүүлэлтийн байгууламж зэрэгт ангилан дараах хүснэгтээр харууллаа.


9.3.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ҮНДСЭН ЭЛЕМЕНТУҮД

Ногоон байгууламжийн нэгж элементүүд нь ногоон байгууламжийн ангилал бүрд хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж тааламжит орчин бий болгох, тус тусын үүрэг зорилгоороо ялгарах онцлогтой байж, түүнтэй уялдуулан байрлуулах ургамлыг зөв сонгон, уран сайхнаар хослуулан байрлуулах нь ландшафтын архитекторын мэдрэмж, ур чадвараас шалтгаална.


Хүснэгт 9.6 Ногоон байгууламжийн үндсэн элементүүд

№	Үндсэн элементүүд	Ерөнхий агуулга
1	Ганц нэгээр суулгасан мод, сөөг	Зүлгэн дунд мод болон сөөгийг бусдаас онцгойлон ганц нэгээр тарьж суулгасныг хэлнэ. Иш, титэм, цэцэг, навчны сайхнаар орчноо чимэглэж чадах навчит болон шилмүүс мод, сөөг байна. Цэцэрлэгт хүрээлэнгийн амралтын хэсгүүдэд ашиглахад тохиромжтой.
2	Бүлэг мод, сөөг	Зүлэг бүхий талбайд мод, сөөгийг 2 түүнээс дээш хэд хэдээр суулгасан хэлбэр юм. Зохиомжид, хоорондын зайг нормчлохгүй. Нэг хэсэгт нэг юм уу хэдэн хэдэн төрлийн янз бүрийн өндөртэй мод, сөөг байж болно.
3	Эгнүүлэн суулгасан мод, сөөг	Замын хажуугаар юм уу барилга байгууламжийн хоёр талаар гудамжинд нэг эгнээгээр суулгасан моддыг хэлнэ. Модлог ургамлыг цэцэрлэгт хүрээлэнгийн хамгаалалтын зурваст нэг юм уу хэд хэдэн эгнээгээр суулгахад ашиглаж болно.
4	Туж мод	Их хэмжээний талбайд олон зуун мод суулгаж ойжуулсан хэлбэр юм. Үүнийг томоохон цэцэрлэгт хүрээлэн байгуулахад хэрэглэнэ.
5	Ногоон хана	Цэцэрлэгжүүлэлтийн зохиомжоос өвөрмөц онцлогтой, барилга байгууламжийн хана, туурганд асаж, ороодог ургамлаар бүрхүүлж ургуулах хэлбэр юм.
6	Тусгаарлагч хана	Цэцэрлэг, паркийн дотор зарим хэсгийг бусдаас тусгаарласан байдлаар “Г”, “П” маягтай юм уу хагас дугуй “нум” хэлбэрүүдээр нэг эгнээ мод, сөөг суулган танаж хяргасан хэлбэр юм.
7	Таримал хашлага	Цэцэрлэгт талбайг хүний хөл хөдөлгөөнөөс хамгаалан тусгаарласан буюу паркийн доторх аль нэг хэсгийг нөгөө хэсгээс заагласан хашлага юм.
8	Эмжээр	Замын хашлаганы гадна тал, зүлгийн захаар 0.5м-ээс өндөргүй сөөг сөөгөнцөр тарих юм.

9	Хэлбэржүүлсэн чимэглэлийн ургамал	Энэ нь хүн зориудаар ногоон ургамлыг янз бүрийн хэлбэр гарган тарьсан, зассан, амьтан болон геометрийн элдэв уран дүрс үүсгэсэн шийдлүүд.
10	Савтай мод, сөөг	Модлог болон өвслөг ургамлыг тусгай зориулалтын саванд суулгасан хэлбэр. Зөөврийн цэцэрлэг бий болгоход ашигладаг.



Зураг 9.1 Бүлэг мод, сөөгийн хослол зохиомж



Зураг 9.2 Эгнүүлэн суулгасан мод, сөөг



Зураг 9.3 Таримал хашлага



9.4 Савтай мод, сөөг



9.5 Хэлбэржүүлсэн мод, сөөг

9.3.2 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛСЭН ЗАМ, ТАЛБАЙН ХУЧИЛТУУД

Хот тосгоны гудамж, замын сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, дугуйн зам, хөдөлгөөн тусгаарлах зурвас, аюулгүйн тойрог, ногоон байгууламж, тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарц, газрын доорх инженерийн байгууламж, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламж зэргийг хамруулан иж бүрэн төлөвлөнө (Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм-БНбД 30.01.04).

Нийтийн эзэмшлийн талбай, авто зогсоол, нийтийн тээврийн зогсоол, цэцэрлэгт хүрээлэн болон авто замын дагуу байрлах явган хүний замыг төлөвлөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал, саадгүй зорчих нөхцөлийг хангана. Явган хүний замыг төлөвлөхөд явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага UCS0901B:2020-ыг дагаж мөрдөнө.

Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжүүлэх талбайн тохижилтын нэгж элементүүд болох явган хүний зам, талбайг зориулалт тус бүрээр нь гүйцэтгэнэ.

Хүснэгт 9.7 Цэцэрлэгжүүлэлтийн зам, талбайн хучилтууд

№	Үндсэн элементүүд	Агуулга
1	Явган хүний зам, талбай	Зөвхөн явган зорчигчид ашиглах зориулалттай, авто зам болон бусад хэсгээс хашлагаар тусгаарлагдсан, явган хүн, харааны бэрхшээлтэй хүн, тэргэнцэртэй хүн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн явганаар зорчих чөлөөт зам талбайг хэлнэ.
2	Дугуйн зам, дугуйн зогсоол	Унадаг дугуйн хөдөлгөөнд зориулсан унадаг дугуйн тэмдэг бүхий замын хэсгийг хэлнэ.
3	Налуу газрын зам	Явган зорчигчийн ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангасан, 18%-аас дээш дагуу налуутай хэсгүүдийг хэлнэ.
4	Амарч зугаалах талбай	Аялагч, амрагчдын амрах тав тухыг бүрдүүлсэн хатуу хучилттай талбайг хэлнэ.
5	Хүндэтгэлийн талбай (Дурсгалын талбай)	Түүхэн, алдар нэр хүндтэй хүмүүст зориулан хүндэтгэл үзүүлэх зорилгоор байгуулсан талбайг хэлнэ.
6	Тоглоомын талбай	Зориулалтаас нь хамаарч бетон, элс, резинен (зөөлөн) хучилтаар тохижуулсан талбайг хэлнэ.
7	Тусгай зориулалтын талбай (арга хэмжээ зохион байгуулах)	Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн ангилалд хамаарагдах талбайг хэлнэ.
8	Олон зориулалтын талбай	Олон нийтэд мэдээлэл түгээх, соёл, боловсрол, урлагийн тоглолт болон арга хэмжээ зохион байгуулахад зориулагдсан талбайг хэлнэ.
9	Спортын талбай	Амрагч, аялагчийн спортоор хичээллэх тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон талбайг хэлнэ.

9.3.3 АРХИТЕКТУРЫН БАГА ЭЛЕМЕНТҮҮД

Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж, тохижуулах талбайд ашиглагдах архитектурын бага элементүүдийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 9.8 Архитектурын бага элементүүд

№	Үндсэн элементүүд	Ерөнхий агуулга
1	Сандал	Явган замын дагуу болон амрах талбайд иргэдийн амрах тав тухтай орчинд газрын түвшнээс өндөрлөсөн түшлэг (түшлэггүй) хийцтэй элементийг хэлнэ.
2	Сүүдрэвч	Өөрийн бичил цаг уурыг бий болгож хүрээлэн буй орчны тав тухыг сайжруулж, салхи, нарны гэрэл, тоос шороо, дуу чимээнээс хамгаалдаг.
3	Саравч	Барилга байгууламжийг нэмэлт өргөтгөлийг хийж, хаалттай нээлттэй орон зайн хоорондын хамаарлыг өөрчлөх замаар цэцэрлэгийн бүтцийг гоёмсог болгон чимэглэхэд ашигладаг.
4	Гэрэлтүүлэг	Гэрэлтүүлэг төлөвлөлтийн салшгүй нэг хэсэг бөгөөд шөнө цэцэрлэгт хүрээлэнгийн аюулгүй тав тухтай байдлыг бүрдүүлж өгдөг. Гэрэл бол маш нарын инженерийн цогц ажиллагаа юм. Иймээс гэрэлтүүлгийг 2 чиглэлд хуваана. Гэрэлтүүлгийн гол үүрэг нь задгай талбай, цэцэрлэгт байрлаж буй эд юмсыг сайтар харагдуулахад оршино
6	Баримал	Баримал нь урлагийн томоохон төлөөлөгч бөгөөд ландшафтын орон зайг чимэглэдэг чухал элементийн нэг юм. Баримал нь хүний анхаарлыг татах ёстой бөгөөд бусад хэсгүүдтэй маш сайн зохицсон байх хэрэгтэй.
7	Тоглоом	Хүүхэд залуучуудын тоглох таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, тоноглогдсон элементийг хэлнэ.

8	Спортын тоног, төхөөрөмж	Гадна талбайд иргэдийн дасгал сургуулилт, хөдөлгөөн хийхэд зориулагдсан стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг хэлнэ.
9	Хашлага, хайс, хашаа	Ногоон байгууламж болон зам талбайг тусгаарлах, хамгаалах зориулалттай.
10	Хогийн сав	Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн савыг хэлнэ.
11	Хяналтын камер	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг орчин үеийн техник технологийг ашиглаж, хянах шалгах зориулалттай төхөөрөмж юм.
12	Тэмдэг, тэмдэглэгээ	Нийтийн эзэмшлийн заах, анхааруулах, мэдээлэх, хориглох зэрэг бүх талуудын аюулгүй байдлыг хангах зориулалттай.
13	Бусад элементүүд	Ашиглалтын зориулалттай архитектурын бага элементүүд хамаарагдана.

9.3.4 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН БАЙГУУЛАМЖУУД

Хотын ногоон байгууламжийн ландшафтыг иргэд, аялагчдын тав тух, нийгмийн соёл боловсрол, хөгжил дэвшлийг сайжруулах зорилгоор хот чимэглэлийн урлагийн бүтээлүүдийг гоо зүй, уран сайхны аргаар инженерчилсэн байгууламжийг хамруулна.

Хүснэгт 9.9 Цэцэрлэгжүүлэлтийн байгууламжууд

№	Байгууламжийн нэр	Ерөнхий агуулга
1	Усан байгууламж	Байгалийн болон хиймэл нуур, цөөрөм, хүрхрээ, голын салаа, хуурай зэргийг хэлнэ.
2	Цэцэгт байгууламж	Нэг болон олон наст цэцгийг өнгө хэлбэр, хэмжээгээр нь хослуулан тарьсан цэцгийн мандал юм. Цэцэгт байгууламжийг зориулалтаар нь хөвөө, эмжээр, мандал, зайдам, бүлэглэх, ганц нэгээр тарих, хээ угалз, чулуун зохиомж зэргээр ангилна.
3	Хөшөө, дурсгал	Улс орны болон бүс нутгийн соёл урлаг, түүхэн үйл явдлыг харуулсан, оюун сэтгэлгээний хөгжлийн илэрхийлэл болсон, архитектур, дүрслэх урлагийн шийдэл юм.
4	Монументаль чимэглэл	Хотын тохижилтод гоо зүйн өндөр ач холбогдолтой. Түүх, соёл, ёс суртахууныг уран сайхны сэтгэлгээгээр илэрхийлсэн байгууламжийг хэлнэ.
5	Усалгааны систем	Цэцэрлэгжүүлсэн талбайг дэвшилтэт технологийн тусламжтайгаар системчилсэн усалгааг хэлнэ.
6	Далан, суваг	Байгалийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлсэн шороон байгууламж
7	Түшиц хана	Энэ төрлийн бүтэц нь өөр өөр төрлийн хөрсний налууг нуралтаас хамгаалсан байгууламж юм.
8	Зогсоолын байгууламж	Нийтийн тээврээр үйлчлүүлж буй иргэдийг нар, салхи, борооноос хамгаалах үүрэгтэй байгууламж юм.
9	Мэдээллийн самбар	Иргэдэд мэдээлэх, таниулах зориулалт бүхий байгууламжийг хэлнэ.
10	Рекламын самбар	Иргэдэд зар сурталчилгааны зориулалт бүхий талбайг хэлнэ.
11	Бусад байгууламж	Хот суурин газарт гоёл чимэглэлийн зориулалттай байгууламжууд хамаарагдана.

10. НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ ТООЦООЛОХ ЗАРЧИМ, АРГА

Одоогийн ногоон байгууламж болон ногоон байгууламжийн үзүүлэлтийг тооцоолох үед хүн амын тоо болон эдэлбэр газрын тоо баримтыг тус тусад нь ашиглах ёстой; Төлөвлөлтийн хугацаа, хот байгуулалтын газрын талбайн хэмжээ, хүн амын статистик мэдээлэл нь хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж, нэгдсэн хураангуй тооцоо хийх шаардлагатай байдаг.

10.1 Эдэлбэр газрын талбайг хавтгайн проекцын дагуу тооцож, хэсэг тус бүрийг зөвхөн нэг удаа тооцно.

10.2 Эдэлбэр газрын тооцоонд ашигласан зургийн масштаб, тооцооны нэгж болон статистикийн нарийвчлал нь хот төлөвлөлтийн холбогдох үе шатны шаардлагад нийцсэн байна.

10.3 Ногоон байгууламжийн статистикийн гол үзүүлэлтүүд нь ногоон байгууламжийн хэмжээ, нэг хүнд ногдох ногоон байгууламж, нэг хүнд ногдох цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж, хот суурины ногоон байгууламжийн хэмжээ юм. Үүнийг дараах байдлаар тооцоолно:

$$\lambda_g = [(A_{g1} + A_{g2} + A_{g3} + A_{xg}) / A_c] \times 100\%$$

Томьёололд:

λ_g - Ногоон байгууламжийн хувь (%);

A_{g1} – Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g2} - Хамгаалалтын ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g3} – Эдэлбэр газар дахь ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{xg} – Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_c - Хотын эдэлбэр газрын талбайн хэмжээ(m^2);

$$A_{gm} = (A_{g1} + A_{g2} + A_{g3} + A_{xg}) / N_p$$

Томьёололд:

A_{gm} – Хүнд ноогдох ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2 /хүн);

A_{g1} – Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g2} – Хамгаалалтын ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g3} – Эдэлбэр газар дахь ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{xg} – Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

N_p – Хүн амын тоо /хүн/, байнгын оршин суугч хүн амаар статистик хийх;

$$A_{g1m} = A_{g1} / N_p$$

Томьёололд:

A_{g1m} – Нэг хүнд ноогдох цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2 /хүн);

A_{g1} – Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

N_p – Хүн амын тоо /хүн/, байнгын оршин суугч хүн амаар статистик хийх;

$$\lambda_g = [(A_{g1} + A_{g2} + A_{g3} + A_{xg} + A_{cg}) / A_c] \times 100\%$$

Томьёололд:

λ_G —Хот хөдөөгийн ногоон байгууламжийн хэмжээ (%);

A_{g1} —Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g2} —Хамгаалалтын ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{g3} —Эдэлбэр газар дахь ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{xg} —Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_{cg} —Бүс нутгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ(m^2);

A_c —Хот хөдөөгийн эдэлбэр газрын талбайн хэмжээ(m^2);

10.4 Ногоон байгууламжийн тоо баримтыг хүснэгт 10.1-д зааснаар нэгтгэнэ.

Хүснэгт 10.1 Ногоон байгууламжийн статистик хүснэгт

Ангиллын код	Ангиллын нэршил	Талбайн хэмжээ, га		Хотын бүтээн байгуулалтад эзлэх эдэлбэр газрын хувь /%/		Нэг хүнд ноогдох талбайн хэмжээ		Хот суурины эдэлбэр газрын хэмжээ, %	
		Одоогийн байдал	Төлөвлөлтөөр	Одоогийн байдал	Төлөвлөлтөөр	Одоогийн байдал	Төлөвлөлтөөр	Одоогийн байдал	Төлөвлөлтөөр
Н	Нийтийн зориулалттай ногоон байгууламж								
Х	Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж								
Т	Тусгай зориулалтын ногоон байгууламж								
Нийт									
Б	Байгалийн үзэмжит газрын ногоон байгууламж								
Нийт									
.....оны одоогийн хотын эдэлбэр газар.....га, одоогийн хүн ам сая хүн оны төлөвлөлтийн хотын бүтээн байгуулалтын эдэлбэр газар-----га, төлөвлөсөн хүн ам.....сая хүн оны хотын ерөнхий төлөвлөлтийн эдэлбэр газар.....га; өнөөгийн нийт хүн ам.....сая хүн; төлөвлөсөн нийт хүн ам..... сая хүн									

11.ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн зураг төсөл нь нэгдсэн төлөвлөлт, зөв зохион байгуулалт, эдэлбэр газрын нөхцөл байдалд нийцсэн, архитектур төлөвлөлтийн зарчимд уялдуулна.

11.1 ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

11.1.1 Хотын уур амьсгал, үндэс угсаа, зан заншил, уламжлалт шинж чанар, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, төлөвлөлт хийгдэх эдэлбэр газарт үнэ цэнтэй нуур цөөрөм, усан байгууламж, хөрс, ургамалжилтын онцлог, зам, барилга байгууламж болон ландшафт зэргийг төлөвлөлтөд хамруулна.

11.1.2 Орон сууцны хорооллын ландшафтын архитектурын төлөвлөлтөд зам талбайн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн гэрэл, агаарыг цэвэршүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй, тохь тухтай амьдрах орчныг цогцоор нь бүрдүүлэх.

11.1.3 Явган хүний зам нь оршин суугчдын бие бялдар, алхах нөхцөлийг хангах орчныг бүрдүүлж, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тухыг хангах.

11.1.4 Ногоон байгууламж нь борооны ус нэвтрэх, хадгалах чадамжтай байх.

11.1.5 Дээврийн ногоон байгууламжийн зузаан нь <50.0 см байх ёстой бөгөөд газар доорх барилгын дээвэр дээрх ногоон байгууламжийн зузаан нь < 2.0 м байна.

11.1.6 Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн зураг төсөл нь дөрвөн улирлыг харгалзан тохижуулсан байх шаардлагатай бөгөөд одоо байгаа мод, ногоон байгууламжийг төлөвлөсөн хэмжээгээр хадгалах, ашиглах нь зүйтэй. Модны ишний диаметр нь ≥ 30 см бүхий том модыг анхны байрлалд нь хадгалах хэрэгтэй.

11.1.7 Орон сууцны хорооллын ногоон байгууламжид хамаарагдах амралтын байгууламжид суух сандал, сүүдрэвч, саравч гэх мэт архитектурын бага хэлбэрүүдийг төлөвлөх шаардлагатай.

11.1.8 Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6 м^2 -ээс багагүй байна. Орон сууцны хорооллын ногоон бүсэд амралтын, хүүхдийн тоглоомын, явган замын талбайг оруулан тооцох ба нийт эзлэх талбай нь ногоон бүсийн талбайн 30%-аас ихгүй байна (Тайлбар: Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03, хүснэгт-3).

Хүснэгт 11.1 Суурьшлын бүсийн цэцэрлэгт хүрээлэнгийн нэг хүнд ноогдох талбайн хэмжээ

Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	Ногоон байгууламжтай талбай, м2/хүн		
	Их хот, том хот	Дунд хот	Бага хот
Бичил хороолол ба хороолол дундын цэцэрлэгт хүрээлэн	3	2	2

(Тайлбар: Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03, хүснэгт-3)

Хүснэгт 11.2 Ногоон байгууламжийн эдэлбэр газар, орон зайн хэмжээ, хүрэлцэн очих хугацаа

Ногоон байгууламжийн төрөл	Байршилт	Талбай, га	Радиус, км	Очих хугацааны хамгийн их цаг
Орон сууцны хороолол дундын цэцэрлэгт хүрээлэн	Орон сууцны барилгын доторх	3	1	Явган 15-20 мин
Бичил хороолол ба хороолол дундын цэцэрлэгт хүрээлэн	Орон сууцны хорооллын доторх	1	0.5	Явган 5-7 мин

(Тайлбар: Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03, хүснэгт-4)

11.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТАРИЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

11.2.1 Шинээр баригдсан орон сууцны хорооллын ногоон байгууламжийн хувь хэмжээ 40%-аас багагүй, хуучин суурьшлын бүсийн ногоон байгууламжийн хэмжээ 25%-аас багагүй байна.

11.2.2 Ногоон байгууламжийн мод, сөөгийн эзлэх хувь $\geq 60\%$ байна.

11.2.3 Зүлэг тарих талбай нь $\leq 20\%$ байна.

11.2.4 Мөнх ногоон мод нь нийт модны 30%-аас дээш хувийг эзэлнэ.

11.2.5 Амралтын талбайн ногоон байгууламж (идэвхтэй амрах)

- Оршин суугчдын гадна талбайн дасгал хөдөлгөөн хийх шаардлагыг хангасан байх;
- Чөлөөт цагаа өнгөрүүлэх, өндөр настнуудын амрах газар, хүүхдийн тоглоом болон спорт, фитнесээр хичээллэх зэрэг газрууд нь нарны гэрлийн стандарт, сүүдрэвчийн шаардлагад нийцсэн байх;
- Тоглоомын талбайн байршлыг сонгохдоо хүүхдийн тоглох үйл явцад үүсэх дуу чимээ, шуугиан нь хүрээлэн буй орчны оршин суугчдад үзүүлэх нөлөөг бүрэн тооцоолох ёстой бөгөөд тоглоомын талбайн захыг хамгийн ойрын байшингийн гадна цонхноос ≥ 8.0 м зайд байрлуулна;
- Ногоон байгууламж нь төвлөрсөн ногоон байгууламжийн нийт талбайн 65 %-аас багагүй байна;

11.2.6 Барилга байгууламжийн хажуугийн ногоон байгууламж

- Сүүдэрлэх хэсэгт сүүдэрт тэсвэртэй ургамал тарих;
- Цонхны ойролцоо өндөр мод, бут сөөг төлөвлөхгүй байх;

11.2.7 Тохижилт, үйлчилгээний төхөөрөмжийн орчны ногоон байгууламж

- Хог хаягдлын цэг, цахилгааны шит, тоолуурын хайрцаг зэрэг тохижилт үйлчилгээний төхөөрөмж нь мод, сөөгөөр хүрээлсэн байх;
- Газар доорх машины зогсоолын орц, гарцын хэсэгт зохих ёсоор ногоон байгууламжийн төлөвлөх;

11.2.8 Авто замын дагуух ногоон байгууламж


- Замын зорчих хэсгийн хоёр тал нь мод, сөөг, зүлэгжүүлэлтийг ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг тооцон төлөвлөх;



Зураг 11.1 Зам дагуух ногоон байгууламжийн борооны усыг ашиглах төлөвлөлт

11.2.9 Борооны ус хураах ногоон байгууламж

- Борооны усыг цуглуулах, зайлуулах ажлыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн талбайн байгалийн цөөрөм, шуудуугаар хуримтлагдсан усыг бүрэн ашиглаж, орон сууцны хорооллын өнгө үзэмж бүтээн байгуулалт, амьдрах орчныг тохиромжтой бүс болгон төлөвлөсөн байх.
- Хотгор газар, зүлэгжүүлсэн гүехэн шуудуу, ус нэвчүүлэх цөөрөм гэх мэт газруудад чийгт тэсвэртэй ургамлыг сонгон төлөвлөнө.
- Хорооллын замын хоёр хажуугийн ногоон байгууламж нь 10 см хүртэл хотгор байх ёстой бөгөөд хүрээлэн буй орчны урсгал ус болон борооны усыг шингээх чадамжтай байх.



Зураг 11.2 Борооны усыг ногоон байгууламжид хуримтлуулах загвар

11.2.10 Ногоон байгууламжийн тарилтын зураг төсөл

- Улирал бүрээр чимэглэлийн үзүүлэлтийн хувирлыг тооцон мод, таримал ургамлыг төлөвлөх;
- Хүүхдийн тоглоомын талбайн эргэн тойронд харааны шугамыг хаасан мод тарихгүй байх. Үзэгдэх орчныг нээлттэй төлөвлөж, насанд хүрэгчдийн хүүхдэдээ тавих хяналтыг хөнгөвчлөх ёстой;
- Авто зогсоолын талбайг модоор хүрээлэгдсэн сүүдэртэй байхаар төлөвлөх. Тарьсан мод нь зогсоолын хэмжээ, нэвтрэх өргөн, эргэх радиусын шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд модны мөчрийн урт >2.5 м байх;
- Эртний болон ховор модыг хамгаалах.

11.2.11 Модны төрөл зүйлийн сонголт

- Орон нутгийн нөхцөлийг харгалзан ургамлын бүлгийг голлох мод, сөөг, зүлэг хослуулан төлөвлөлтийн үндсэн хэлбэрт нийцүүлэх;
- Үйл ажиллагаа явуулдаг талбай түүний орчинд хортой, өргөст ургамал тарихгүй, тарьсан модны мөчрүүд 2.2 м байх ёстой;
- Орон сууцны хорооллын замын хажуугийн хоёр талд том сүүдэртэй, зөв хэлбэртэй модыг сонгох ба мөр хоорондын зайг 5.0 м-ээс 7.0 м-ийн хооронд тарина;

11.2.12 Модлог ургамал ба барилга байгууламжийн хоорондын зайн хэмжээ

- Ургамал ба барилга байгууламж (бүтэц) -ын хоорондох хамгийн бага зайг хүснэгт 11.3-д, дамжуулах хоолой бусад байгууламж, ногоон

байгууламжийн модны төрөл хоорондох хамгийн бага хэвтээ зайг хүснэгт 11.4-т харуулав.


Хүснэгт 11.3 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ ногоон байгууламжийн хоорондын зай

Барилга байгууламжийн нэр	Хамгийн бага зай (м)	
	Модны их бие хүртэл	Бут, сөөгийн их бие хүртэл
Барилга байгууламжийн гадна хананаас	5.0	2.0
Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлаганы захаас	1.0	0.7
Авто машин, троллейбусны замын зах, хашлагаас	1.5	0.6
Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
Түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас	1.5	0.6
Спортоор хичээллэх талбай	3.0	3.0


(Тайлбар: Барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ MNS 5973:2009, хүснэгт-1)




Зураг 11.3 Барилга байгууламжийн гадна хананаас алслах зай



Зураг 11.4 Барилга байгууламжийн өмнөх зорчих хэсгийн төлөвлөлт



Зураг 11.5 Барилга байгууламж гадна хана, тоног, шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зайн хэмжээ / БНБД 30-01-04 /




Зураг 11.6 Авто замын хашлаганы захаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ

Хүснэгт 11.4 Дамжуулах хоолой, бусад байгууламж болон ногоон байгууламжийн модны төрөл хоорондох хамгийн бага зай

№	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээний тэнхлэг	
		Шилмүүст болон навчит модны гувар, ишний тэнхлэг хүртэл/ м	Сөөг, сөөгөнцрийн гол хүртэл/ м
1	Дулаан дамжуулах яндан хоолойноос	3.0	3.0
2	Цэвэр бохир усны яндан хоолойноос	3.0	3.0
3	Цахилгаан дамжуулах кабель утаснаас	2.5	2.0
4	Троллейбус болон гэрлийн шонгоос	5.0	2.0


(Тайлбар: Барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ MNS 5973:2009, хүснэгт-1)




Зураг 11.7 Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийг алслах зайн хэмжээ



Зураг 11.8 Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зай



Зураг 11.9 Зеңиц ханын дотоод ирмэг буюу улнаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ



Зураг 11.10 Гудамж замын дагуух цахилгааны шугамаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ

11.3 БАЙР ЗҮЙН ЗУРАГ ТӨСӨЛ

- Байр зүйн зураг төсөл нь хорооллын ерөнхий төлөвлөлтийг ханган байгалийн болон бичил газрын онцлогтой харьцуулж, харьцангуй өндөрлөг нь хүрээлэн буй орчин, ногоон байгууламжийн байршил дээр үндэслэсэн байх.
- Байр зүйн зураг төсөлд цэцэрлэгийн ландшафтын болон гадаргын усны урсцыг тооцож, газрын гадаргын ус зайлуулах хоолойн налууг хорооллын зам, жижиг талбай, гаднах ус зайлуулах шугамтай холбож өгөх хэрэгтэй.
- Хорооллын дотоод орчныг гадаад орчинтой уялдуулах хэрэгтэй.

11.4 ЗАМ, ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ


11.4.1 Аяллын маршрутын зураг төсөл

- Аяллын гол замын дагуу налуу <8% байх ёстой. Төв зам дээр шат төлөвлөхгүй, заавал төлөвлөх шаардлагатай бол дагуу налуу нь <36% байх ёстой.
- Салаа зам ба туслах замын дагуу налуу <18% байх ёстой. Замын дагуу налуу >15%-тай хэсгүүдийн хувьд хучилтыг гулсалтын эсрэг технологиор,


дагуу налуу $>18\%$ -тай хэсэгт шат төлөвлөж, гишгүүрийн тоо 2-оос их байх ёстой.

11.4.2 Хучилт ба зам

- Орон сууцны хорооллын эдэлбэр газарт 2 зурвастай зам төлөвлөнө. Барилгын орцны орчимд замын өргөн 5.5 м-ээс багагүй байна.
- Гол зам, орц, гарцыг хаалтгүйгээр төлөвлөх.
- Ногоон байгууламж доторх явган зам болон авто зам хучилтын талбай галын аюулгүйн гарцаас бусад бүх зам ус нэвчүүлэх, агаар нэвтрүүлэх хучилтын материалаар хийсэн байх ёстой.
- Мод тарьсан хучилтын талбайг ус нэвчүүлэх, агаар нэвтрүүлэх хучилтын материалаар хийсэн байх ёстой.
- Нийт хучилтын талбайн 50%-аас дээшхийг ус нэвтрүүлдэг хучилт нь эзлэх ёстой.
- Ландшафтын зам нь тэгш байж, зураг төслөөр дамжуулан хур тунадасны урсцыг ногоон байгууламж руу жигд урсгах боломжийг хангасан байх ёстой.
- Явган хүний зам нь саадгүй, цэцэрлэгжүүлсэн талбайн тэргэнцэртэй хүний замын дагуу налуу нь $>4\%$ байх ёсгүй; зөвхөн тэргэнцэртэй хүний зориулалтын зам $>8\%$ байх;
- Амрах сандлыг тохируулахдаа тэргэнцэр багтах зай үлдээх.



Зураг 11.11 Явган хүний зам



Зураг 11.12 Налуу замд хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй хүний түр амрах хэсэг

11.4.3 Чийрэгжүүлэх талбай


- Чийрэгжүүлэх талбай нь суурьшлын бүсэд тархсан, оршин суугчид хэрэглэхэд дөт мөн саад учруулахгүй байх.
- Чийрэгжүүлэх талбайн хажуугаар авто тээврийн хэрэгсэл, моторт бус тээврийн хэрэгсэл байх ёсгүй, мөн талбайгаар өнгөрч болохгүй бөгөөд хөдөлгөөний гарц гаргах хэрэгтэй.
- Чийрэгжүүлэх талбай нь нарны тусгал болон салхи нэвтрэхүйц байх ёстой бөгөөд газрын гадаргад спортоор хичээллэхэд тохиромжтой гөлгөр, халтиргаагүй хучилтын материал сонгож, тэдгээр нь цэвэрлэхэд амар, элэгдэлд тэсвэртэй, ялзрахгүй байх шаардлагыг хангасан байх ёстой.
- Чийрэгжүүлэх хэрэгслийг ахмад настнуудын онцлогт тааруулж, аюулгүй байдлаас хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй.
- Амралтын талбайг чийрэгжүүлэх талбайн эргэн тойронд байрлуулж, нарны шууд тусгалаас хамгаалсан мод тарих, зохих хэмжээний суудал, амралтын талбайг байрлуулах нь зүйтэй.

11.4.4 Амралт чөлөөт цагийн талбай

- Үүнийг орон сууцны хороолол (төв , гол хаалга гэх мэт)-ийн хүн их цугладаг газар байрлуулж, төвлөрсөн ногоон байгууламжийг хамт төлөвлөж, талбайн ихэнх хэсгийг нарны гэрэл, агааржуулалттай байх нөхцөлийг хангана.
- Эргэн тойронд сүүдрэвчтэй мод, сандлыг байрлуулан хөрш зэргэлдээ оршин суугчдад саад учруулахгүйгээр гэрэлтүүлгийг зөв зохистой зохион байгуулах хэрэгтэй.
- Хучилтыг ихэвчлэн хатуу материалаар хийсэн байх ба хэлбэр болон өнгө тохирсон байдал нь тодорхой загвар, хэв маягийн мэдрэмжтэй байх ёстой бөгөөд гулгамтгай чулуу, шалны хавтан, шил зэргийг ашиглах нь тохиромжгүй. Талбайн орох, гарах гарц нь хашлага саадгүй, зураг төслийн шаардлагад нийцсэн байх ёстой.

11.4.5 Усан байгууламж

- Хороолол дотор янз бүрийн хиймэл усан байгууламж зохион бүтээх боломжтой бөгөөд усан сан бүхий газар нь орон сууцны хорооллын ногоон байгууламжийн 8% -аас хэтрэхгүй байх ёстой.
- Усан байгууламж нь эргэлтийн усан хэлбэрээр хийгдэн, дунд зэргийн ус, борооны ус зэргийг эх үүсвэр болгох бөгөөд усны чанар, цэвэр, эрүүл ахуйг хангах ёстой.
- Хорооллын усан байгууламжийг төлөвлөхдөө цаашид ашиглалтын хүчин зүйлийг харгалзсан зохистой загвар гаргана.
- Усан байгууламж нь борооны ус хадгалах чадамжтай байх.
- Усан байгууламж аюулгүй байдлаас хамгаалах шаардлагыг хангасан байх.
- Орон сууцны хорооллын ногоон байгууламж дахь усжуулалтад ашигладаг ус нь дундын ус эсвэл борооны ус байх ёстой. Услалтын системд ус хэмнэх технологиор ус шүрших усалгааны загварыг сонгосон байх.



Зураг 11.13 Усан байгууламж

11.5 ХАШЛАГА, СААДЫН ЗУРАГ ТӨСӨЛ

Ногоон байгууламж, зам талбайг зориулалтаас хамааран тусгаарлах үүрэгтэй. Хашлага, саадын зураг төслийн болон барилгын төрлүүдийн хамрах хүрээнд: Орц гарц, явган хүний зам, амралтын байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цаг, чийрэгжүүлэлтийн спортын талбай, нийтийн бие засах газар гэх мэт орно.

Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ UCS0001-02:2019 техникийн шаардлагад нийцүүлэх.

- Суурийн налуу нь $\leq 5\%$ -ийн орон сууцны хорооллын ногоон байгууламж нь хашлага, саадын зураг төслийн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд газрын налуу нь $> 5\%$ -аас их орон сууцны хороолол нь хамгийн багадаа нэг хашлага саадын зураг төслийн шаардлагыг хангасан ногоон

байгууламжтай байна.

- Хашлага, саадын зураг төслийн шаардлагыг хангасан орон сууцны ногоон байгууламжийг хаалтгүй орон сууц, дотуур байр бүхий байшингийн ойролцоо байрлуулж, түүнд саадгүй гарцаар хүрэх ёстой.
- Үндсэн үйл ажиллагааны талбай ба зэргэлдээ газар эсвэл замын гадаргуугийн өндрийн зөрүү 300 мм-ээс бага байвал бүх орц, гарц нь саадгүй байх ёстой, өндрийн зөрүү 300 мм-ээс их үед орц, гарц нь 3-аас бага байх үед бүх орц, гарц нь хаалтгүй байх ёстой; 3 буюу түүнээс дээш орц, гарц байх үед 2-оос доошгүй хаалтгүй орц, гарц байх ёстой;
- Орон сууцны хорооллын ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбайн орц, гарцад хараагүй хүний тусгай замыг хийж өгөх.

11.6 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ

Зорчигчдын зорчих хэсэгт хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй, тав тухтай, зорчих нөхцөлийн хангах зориулалттай байнгын суурин гэрэлтүүлгийг төлөвлөсөн байх.

- Гудамж, замын гэрэлтүүлэг нь хот суурин газрын дүр төрхөд ихээхэн нөлөөлдөг тул зураг төсөл гүйцэтгэхээс эхлүүлэн ландшафт, дизайны үзэл баримтлалаар төлөвлөх.
- Ногоон байгууламжийн мод, сөөгийн хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягт тохируулан гэрэлтүүлгийг шийдэж өгнө.
- Ногоон байгууламжийн нэгж элементүүдийн зориулалтаас шалтгаалан гэрэлтүүлгийг сонгоно.
- Зүлэгт талбайд ашиглалтын зориулалтаас нь хамаарч гэрэлтүүлгийг сонгоно.
- Хот суурин газрын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага 1901В:20120 техникийн шаардлагад нийцүүлэх.

12. ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦООЛОХ

12.1 Ногоон байгууламжийн хэмжээг тооцоолох томъёог жишээ (1) -т үзүүлсний дагуу тооцно.

$$\text{Ногоон байгууламжийн талбайн хэмжээ} = \frac{\text{Орон сууцны хороолол доторх төрөл бүрийн ногоон байгууламжийн нийт талбайн хэмжээ}}{\text{Орон сууцны хорооллын эдэлбэр газрын хэмжээ}} \times 100\% \quad (1)$$

12.2 Мөнх ногоон модны эзлэх хувийг тооцоолох томъёог жишээ (2) -т үзүүлсний дагуу тооцно.

$$\text{Мөнх ногоон модны эзлэх хувь} = \frac{\text{Орон сууцны хороолол доторх мөнх ногоон модыг тарих тоо}}{\text{Орон сууцны хорооллын эдэлбэр газрын талбайн модны нийт тоо}} \times 100\% \quad (2)$$

12.3 Ногоон байгууламжийн хэмжээнд хамрагдах боломжтой төрөл бүрийн ногоон байгууламжийг дараах журмын дагуу тооцно.

- Ногоон байгууламж дахь зөрөг зам, гишгүүр, архитектурын бага хэлбэр, усан байгууламж зэргийг ногоон байгууламжийн үзүүлэлтийн тооцоонд оруулсан болно.
- Төвлөрсөн ногоон байгууламж дахь хорооллын байгууламжийн талбайг эс тооцохоос гадна, ногоон байгууламжийн талбай 65% -аас их үед хатуу хучилттай талбайг ногоон байгууламжийн түвшний үзүүлэлтийн тооцоонд оруулж болно.
- Архитектурын бага хэлбэрийн элементүүд нь ногоон байгууламжийн нийт талбайн 3% гэж тооцно.
- Хиймэл усан байгууламж нь тус тодорхойлолтын 3.5.10.5 дэх тодорхойлолтын болзлыг хангана, үүнийг бүх талбайн ногоон байгууламжийн үзүүлэлтийн тооцоололд оруулж болох бөгөөд илүүдэл хэсгийг тооцоолохгүй. Хороолол дотор хэрэв байгалийн ба хиймэл усан байгууламж байгаа бол түүнийг нийт ногоон талбайн 8%-д тооцно.
- Мод, сөөгийн хамрах хүрээг зураг дээр боловсруулсан мод, сөөгийн гаднах ирмэгээр төсөөлөн тооцно.
- Зоорины болон хагас подвалын дээврийн хучилтын шорооны гүн нь 2.0 м-ээс их байвал ногоон байгууламжийн барилгын хэсгийг ногоон байгууламжийн талбайд хамруулж болно.
- Нийтэд нээлттэй дээврийн ногоон байгууламжийн хучилтын хөрсний гүн 0.5 м-ээс багагүй бол түүний талбайн 20%-ийг ногоон байгууламжид багтааж болох бөгөөд барилгын өндөр нь 24.0 м-ээс бага байх ёстой.

- Авто зогсоолыг төлөвлөхдөө хучилтын талбайн 20%-ыг зүлгийн ургамлаар хучиж, ногоон байгууламжид хамруулах боломжтой.
- Ногоон байгууламжийн үзүүлэлтийн тооцоог орон сууцны хорооллын ногоон байгууламжийн үзүүлэлтийг зөвшөөрөх, хүлээн авахад ашиглана.

13. ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аж ахуй нэгж, албан байгууллагуудын гүйцэтгэсэн орон сууцны хорооллын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг дараах шалгуур үзүүлэлтээр (хүснэгт 13.1) дүгнэнэ.

Хүснэгт 13.1 Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Техникийн үзүүлэлт, %	Тийм	Үгүй
1	Нийт газар нутгийн хэмжээ, м2			
2	Ашиглалтын цэвэр талбай, м2			
3	Ногоон байгууламжийн талбайн хэмжээ, %		☐	☐
4	Нийт мод, сөөгийн хэмжээ, %		☐	☐
5	Мөнх ногоон модны хэмжээ, %		☐	☐
6	Зүлэгжүүлсэн талбайн хэмжээ, %		☐	☐
7	Усан байгууламжийн талбайн хэмжээ, %		☐	☐
8	Спорт талбайн хэмжээ, %		☐	☐
9	Тоноглогдсон талбайн хэмжээ, %		☐	☐
10	Зам, талбайн хэмжээ, %		☐	☐
11	Архитектурын бага хэлбэрийн элементийн хэмжээ, %		☐	☐

Тайлбар: Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд 75%-аа дээш нөхцөлийг хангасан тохиолдолд “Тийм”, 60-75% хүртэлх нөхцөлд “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ. 1 ба 2 дугаар үзүүлэлтийг дээрх хувьд тооцож оруулахгүй.

БАТЛАВ:

**Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн зураг төсөлд тавигдах
шаардлага техникийн даалгавар**

202.. оны сарын өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	
2	Төслөөр шийдвэрлэх асуудлууд	
3	Төслийн бүрдэл	
4	Төслийн үр дүн	
5	Төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд	
6	Төслийн гүйцэтгэх байгууллага	
7	Төсөл боловсруулж дуусгах хугацаа	
8	Төсөлд шаардагдах хэмжээ	
9	Онцгой нөхцөл	

14. ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

14.1 ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

14.1.1 Хотын ногоон байгууламжийн зураг төслийн агуулгад: Ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл, хэсэгчилсэн зураг төсөл, ажлын зураг төсөл гэх мэтийг багтаасан байх ёстой.

14.1.2 Хотын ногоон байгууламжийн зураг төслийг батлагдсан хотын ногоон байгууламжийн системийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, ногоон байгууламжийн хамрах хүрээ, мөн чанарыг тодруулж, чанар болон байршилд үндэслэн ерөнхий загвар гаргах ёстой.

14.1.3 Хотын ногоон байгууламжийн ерөнхий зураг төсөл нь ногоон байгууламжийн үйл ажиллагааны шаардлагад нийцсэн байх, орон нутгийн нөхцөлд тохируулах, ургамлын өнгө үзэмжийн үр нөлөөг олж авахын тулд хотын экологи, хэрэгцээ, шаардлага, чиг үүргийг тодруулна.

14.1.4 Хотын ногоон байгууламжийн зураг төслийг тухайн газрын бодит байдал дээр үндэслэн боловсруулж, экологийн уугуул орчныг хамгаалах, ашиглах, зохих өөрчлөлт хийх дизайны үзэл баримтлалыг сурталчлах ёстой.

14.1.5 Хотын ногоон байгууламжийн зохион байгуулалт нь олон янз, нэгдмэл байх ёстой ба хэсэг бүрийн төлөвлөлтийн агуулга нь хоорондоо уялдаа холбоотой байна.

Хотын ногоон байгууламж нь хүрээлэн буй орчинтойгоо уялдаатай байх ёстой.

14.1.6 Төрөл бүрийн шинж чанартай хотын ногоон байгууламжид ногоон ургамал тариалах нийт талбайн эзлэх хувь нь одоогийн холбогдох улсын стандартад нийцсэн байна.

Хотын ногоон байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа ургамлыг гол элемент болгон авч, ургамлын сонгохдоо ургамлын экологийн нөхцөл, тарих хэлбэр, ургамлын бүлгүүдийн олон янз байдал, оновчтой байдал зэрэгт анхаарлаа хандуулах.

14.1.7 Хотын ногоон байгууламжийн хүрээн дэх уугуул модыг хадгалж, ашиглах нь зүйтэй. Онцгой шаардлагаар шилжүүлэн суулгасан бол том модыг шилжүүлэн суулгах стандартыг баримтлан ажиллана. Модны тойргийн диаметр 30 см ба түүнээс дээш өндөртэй, удаан ургадаг модны төрөл зүйлийг хэвээр нь хадгалах хэрэгтэй.

14.1.8 Хотын ногоон байгууламж дахь эртний, ховор модыг ургаж байгаа байршилд заавал байлгах.

14.1.9 Хотын ногоон байгууламжийн архитектурын бага хэлбэрийг хүрээлэн буй орчинтой уялдуулж дараах шаардлагыг хангасан байх:

- Цэцэрлэгт хүрээлэн дэх архитектурын бага хэлбэрийн талбайг цэцэрлэгт хүрээлэнгийн амралт, үйлчилгээ, менежмент, ногоон байгууламжийн шинж чанар, цар хүрээний дагуу тодорхойлно. Жижиг хэлбэрийн цэцэрлэгт

хүрээлэнгийн ногоон байгууламжид 3%-аас ихгүй, том хэлбэрийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжид 5% байх. Зоопарк, ботаникийн цэцэрлэг, амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэнгийн харьцааг зохих ёсоор нэмэгдүүлэх боломжтой.

- Бусад ногоон байгууламж дахь архитектурын бага хэлбэрүүд нийт талбайн 2%-аас хэтрэхгүй байх ёстой.

14.1.10 Хотын задгай ногоон байгууламжийн гарах, орох гарц, төв зам болон барилга зэргийг саадгүй нэвтрэх зориулалттай байхаар төлөвлөж, хотын замын аюулгүйн гарцтай холбосон байх.

14.1.11 Газар хөдлөлтийн хүч 6 баллаас дээш (үүнд 6 балл орно) бүсэд хотын задгай ногоон байгууламжид гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах тусгай байгууламж байгуулах шаардлагатай.

14.1.12 Аялал жуулчлалыг хамарсан хотын ногоон байгууламжуудад холбогдох аюулгүй байдлыг анхааруулах тэмдгийг байрлуулсан байх.

Хотын ногоон байгууламж дахь том хэлбэрийн намгархаг цөөрөм, борооны ус тогтдог намгархаг газрууд нь аадар борооны үед ажиллагсдын аюулгүй байдлыг хангах үүднээс анхааруулах тэмдэг, эрт зарлан мэдээлэх системээр тоноглогдсон байх.


14.1.13 Хотын задгай ногоон байгууламжийг амрагч, аялагчдын тархалт, нягтралын дагуу сандал, хогийн сав, гэрэлтүүлэг зэрэг үйлчилгээний байгууламжаар тоноглогдсон байх.

14.1.14 Хотын ногоон байгууламжийн зураг төсөл нь байгаль орчинд ээлтэй материалыг онцлон сонгож, нарны эрчим хүч, салхины эрчим хүч, борооны ус зэрэг нөөцийг бүрэн ашиглахын тулд эрчим хүч хэмнэх арга хэмжээ авсан байх.

14.1.15 Хотын ногоон байгууламжийн зураг төсөл нь хэмнэлт, хэрэглээний зарчимд нийцсэн байх ёстой бөгөөд тухайн газар нутгийн байршил, хөрсний төрөл, гидрологийн усны систем, урсцын байдал гэх мэт бодит нөхцөл байдлыг цогцоор нь авч үзэн дараах шаардлагыг хангасан байх ёстой.

- Хотын ногоон байгууламжийн зураг төсөл нь ногоон байгууламжийн төрөл бүрийн ашиглалт, экологи, ландшафт, амралт чөлөөт цагийн чиг үүргийг нэн түрүүнд хангаж, хотын төлөвлөлтийн өнгө төрх, хэлбэр загварыг үндэслэн холбогдох төлөвлөгөөг боловсруулсан байх ёстой;
- Том нуур, цөөрөм, намгархаг газар болон бусад ногоон байгууламжууд нэвчих, хадгалах, цэвэрлэх, ашиглах, зайлуулах зэрэг олон төрлийн техникийн чадварыг ашиглан борооны усны урсцыг сайжруулна;
- Энгийн, хямд өртөгтэй, эх үүсвэрийн урсцыг хянах байгууламжуудыг ашиглах хэрэгтэй. Байгууламжийн тохиргоо нь тухайн газрын ландшафтын зураг төсөлд нийцсэн байх бөгөөд хотын ногоон байгууламжийн ерөнхий талбай, босоо чиглэл, барилга байгууламж, зам гэх мэттэй уялдуулсан байх ёстой;

- Хотын ногоон байгууламжийн борооны усыг ашиглан нэвчилт болон ландшафтын усыг нөхөн сэргээх, цэвэршүүлэхэд суурилж барилга байгууламж, засвар үйлчилгээний зардлыг хэмнэх ёстой.
 - Хөрсний нэвчилт багатай хотын ногоон байгууламжийг хадгалах, дахин ашиглахыг голчилно;
 - Хотын ногоон байгууламж дахь усан санг борооны ус хадгалах байгууламж болгон ашиглаж, ландшафтын зураг төсөлтэй уялдуулна;
- Борооны ус, цас хайлуулах бодисын ногоон байгууламжид үзүүлэх нөлөөллийг тооцох хэрэгтэй. Борооны усны урсгалыг урьдчилан шийдвэрлэх төхөөрөмжийг байгуулна;



Зураг 14.1 Ногоон байгууламжийн борооны усыг ашиглах загвар

14.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ

14.2.1 Ногоон байгууламжийн зураг төслийг ургамлын зохион байгуулалтад зориулж ногоон байгууламжийн ерөнхий дизайны шаардлагыг үндэслэн боловсруулж, тухайн орон нутгийн байгалийн нөхцөлд тохирсон ургамлыг сонгох хэрэгтэй.


14.2.2 Ногоон байгууламжийн зураг төсөлд гаднаас шинэ ургамлын төрөл зүйл (сорт) тарималшуулахдаа хортой ургамлаас зайлсхийх хэрэгтэй.

14.2.3 Ургамлын зохих төрөл зүйлийг талбайн цаг уурын нөхцөл, хөрсний онцлогт тохируулан сонгоно. Хөрсний физик, химийн шинж чанар нь ургамал ургах нөхцөлд нийцсэн байх ёстой бөгөөд борооны ус нэвчих шаардлагыг хангасан байх.

14.2.4 Тарилтын нөхцөл нь экологи, амралт, өнгө үзэмжийн функциональ шаардлагыг хангаж, засвар үйлчилгээ, менежмент хийхэд тохиромжтой байх.

14.2.5 Ногоон байгууламжийн зураг төсөл нь нэгдмэл байдал, хэсэг бүрийн хоорондын уялдаа холбоо, зохицол зэрэг гол үзүүлэлтүүд нь арын фон ба үндсэн модны төрөл зүйл, улирлын өөрчлөлтийг тусгасан байх.

14.2.6 Ургамлын мөчир, цэцэг, навч, жимс болон бусад хэлбэр, өнгийг бүрэн ашиглаж, ургамлыг олон янзын бүтэцтэй, улирлын чанар бүхий өөрчлөлттэй, ургамлын өнгө үзэмжийг бүрдүүлэхийн тулд зохистой байдлаар төлөвлөсөн байх ёстой.



Зураг 14.2 Мод таримал ургамлын хослол зохиомж

14.2.7 Ногоон байгууламжийн зураг төсөл нь модлог ургамлыг голчилж, мөнх ногоон болон навчит модны хослол, хурдан, удаан ургадаг модны хослол, сөөг, өвслөг ургамлын хослол зэрэг ургамлын бүлгээр үүсгэсэн өнгө үзэмж нь экологийн сайн үр нөлөөг бий болгох шаардлагатай.

14.2.8 Суурин газар дахь уугуул сайн ургадаг ургамлыг хадгалж, цэцэрлэгжүүлэлтэд сонгох хэрэгтэй. Шинээр тарьсан модыг уугуул модтой уялдуулж, анхны модны ургалтад нөлөөлөхгүйгээр шийдвэрлэнэ.

14.2.9 Ногоон байгууламжийн зураг төсөл нь төлөвлөлтийн гол байршилд өнгө үзэмжийн харагдах байдлыг ойрын болон урт хугацааны нөлөөллийг харгалзан үзэх.

14.2.10 Хот суурин газрын ногоон байгууламжийн зогсоолын хэсэгт сүүдэрлэх мод, тусгаарлах зурваст зүлгийг төлөвлөх.

14.2.11 Хүүхдийн тоглоомын цэцэрлэгт хүүхдэд хор хөнөөл учруулах хортой болон өргөстэй ургамал тарихыг хатуу хориглоно.



Зураг 14.3 Амралтын талбайд модлог ургамлыг төлөвлөх

14.2.12 Дээврийн ногоон байгууламжийг дээвэр ба барилгын зөвшөөрөгдөх ачаалал ба барилгын дээврийн бүтцийн аюулгүй байдал, ус зайлуулах хоолойд нөлөөлөхгүй байхаар шийдвэрлэнэ.

14.2.13 Дээврийн ногоон байгууламжид ашиглах хөрс нь хөнгөн жинтэй, доод давхарга нь шүүгч, ус зайлуулах давхарга, ус үл нэвтрэх давхаргаар сайн хангагдсан байх ёстой.

14.2.14 Дээврийн ногоон байгууламжийн мод тарих байрлалыг багана эсвэл ялууны дээд хэсэгт байрлуулж, салхинд тэсвэрлэх арга хэмжээг авна.

14.2.15 Дээврийн ногоон байгууламжид гэрэлд дуртай, салхинд тэсвэртэй, тэсвэрлэх чадвар сайтай ургамлыг сонгох.


14.2.16 Зам, уулнаас үүссэн ил налууг зүлгийн ургамал эсвэл хөрс бүрхэгч, асаж авирдаг ургамлын төрлөөр ногоон байгууламжийг бий болгоно.

14.3 АВТО ЗАМЫН ДАГУУХ НОГООН БАЙГУУЛАМЖ

14.3.1 Хотын ногоон байгууламж дах замын зураг төслийг барилга байгууламжтай хослуулан төв зам, туслах зам, явган зам болон талбай зэргийг замын системд уялдуулан төлөвлөнө.

14.3.2 Хотын ногоон байгууламж нь 2 ба түүнээс дээш орц, гарцтай байх. Орц, гарцын байршил нь хот төлөвлөлт, ногоон байгууламжийн ерөнхий зохион байгуулалтын шаардлагад нийцсэн байна.

14.3.3 Ногоон байгууламжийн гол зам нь туслах замыг бүрдүүлж, авто тээврийн хэрэгслээр явах нөхцөлийг хангана. Төв замын өргөн 3.0 м-ээс багагүй байна. Гал унтраах машин өнгөрөх гол замын өргөн 3.5 м-ээс багагүй, явган замын өргөн 0.8 м-ээс багагүй байна.



Зураг 14.4 Хоёр урсгалтай авто замын ногоон зурвасыг төлөвлөх

14.3.4 Ногоон байгууламж дахь зам нь газар нутгийн онцлогоос шалтгаалан шулуун, юм уу долгионтой байх. Төв замын налуу нь 8% -аас ихгүй, уулын гол замын дагуух налуу нь 12% -аас ихгүй байна. Салаа зам ба явган замын налуу нь 18% -аас ихгүй байна. Налуу 18% -аас хэтэрсэн үед шат байрлуулж шатны гишгүүрийн тоо 2-оос багагүй байна.

14.3.5 Хотын ногоон байгууламж дахь замуудыг ус, агаар нэвтрүүлдэг хучилтын материал, сэргээгдэх материал ашиглан хийх хэрэгтэй. Нэвчилттэй хучилт нь ачаалал даах, ус нэвтрүүлэх чадвар, халтиргаанаас хамгаалах үйлчилгээ, удаан эдэлгээний шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байх:

- Нэвчилттэй хучилт нь авто замын доод давхаргын бат бэх, тогтвортой

байдалд илүү их эрсдэл учруулах тохиолдолд хучилтын хагас нэвчилттэй байгууламжийг ашиглаж болно;

- Хөрсний ус нэвтрүүлэх чадвар хязгаарлагдмал үед ус нэвтрүүлэх хучилтын суурийн давхаргад ус зайлуулах хоолой эсвэл ус зайлуулах хавтан суурилуулна;

14.3.5 Хөрсний суулттай, цэвдэгтэй бүсэд хучилтын материалыг нөхцөл байдалд үндэслэж тодорхойлно.

14.3.6 Уул, гол мөрний ойролцоо, жуулчдад аюулгүй байдал, аюул ослоос сэргийлж авто замын хувьд хамгаалалтын хаалт тавьж, өндөр нь 1.0 м-ээс их байх.

14.4 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ГҮҮРНИЙ ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

14.4.1 Гүүрний зураг төслийг ногоон байгууламжийн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөл дээр үндэслэж, хүрээлэн буй орчинтойгоо уялдуулан, аялал амралтын шаардлагыг хангасан байх ёстой.

14.4.2 Хүнд даацын тээврийн хэрэгсэл цөөн байхаар тооцож моторт тээврийн хэрэгслийн дайран өнгөрөх гүүрийг хурдны замын хоёрдогч ачааллын 80% -аар тооцож, гүүрний хоёр үзүүрт ачааны хязгаарлалтын тэмдэг тавина.

14.4.3 Явган хүний гүүрний хувьд гүүрний тавцан дээрх ачааллыг 3.5кп/м2-аар тооцож, гүүрний эхэн дээр тээврийн хэрэгслийн хаалтыг тогтооно.

14.4.4 Хашлагагүй гүүр, тавцан болон бусад эрэг орчмын хувьд 2.0 м-ээс дээш өргөнтэй усан доорх аюулгүйн бүсийг заавал байгуулах ёстой бөгөөд усны гүн 0.7 м-ээс хэтрэхгүй байх ёстой. Гишгүүрийн хоёр талын усны хэмжээ 0.5м-ээс ихгүй байна.

14.4.5 Аяллын усан завь дамжин өнгөрөх гүүрнүүдийн хувьд гүүрний ёроол ба усны хэвийн түвшин хоорондын зайны өндөр 1.5 м-ээс багагүй байна.



Зураг 14.5 Цэцэрлэгжүүлсэн талбайн явган гүүр

14.5 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АРХИТЕКТУРЫН ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

14.5.1 Цэцэрлэгийн архитектурын зураг төслийг боловсруулахдаа ногоон байгууламжийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн өнгө үзэмж, үзэсгэлэнт газрууд, амралт, үйлчилгээний барилга байгууламжууд нь архитектурын дизайны хүрээ хэмжээний тодорхойлолтыг хэрэгжүүлэхүйц байхаас гадна дараах зарчмуудыг баримтална:

- Талбайн сонголтыг оновчтой хийх. Орон нутгийн нөхцөлд тохирсон архитектур төлөвлөлтийн зарчмыг мөрдөж, уул, гол, ургамал зэрэг байгалийн орчинтой нийцэж, өнгө үзэмжийг бууруулахгүй байх;
- Хэмжээг тогтоох. Цэцэрлэгт хүрээлэнгээс бусад хотын ногоон байгууламж дахь барилгуудын эзлэх талбай нь нийт газар нутгийн 2% -аас хэтрэхгүй байх ёстой;
- Бүтээлч шинж чанарыг сонгох. Цэцэрлэгийн архитектурын зураг төсөл нь шинэ санаа, шинэ технологи, шинэ материалыг ашиглах, нарны эрчим хүч, салхины энерги, дулааны эрчим хүч, зэрэг байгалийн эрчим хүчийг бүрэн ашиглаж орон нутгийн нийгэм, байгалийн нөхцөлийг ашиглан тухайн газрын онцлогийг тодруулсан үндэсний онцлог бүхий архитектур төлөвлөлтийг байгуулна;

14.5.2 Амьтны тор, хүлэмж гэх мэт цэцэрлэгийн тусгай барилга байгууламжийн зураг төсөл нь амьтан, ургамлын экологийн нөхцөл шаардлагад нийцсэн байх бөгөөд үүний зэрэгцээ аялагчдын үзэх аюулгүй байдлын шаардлагыг хангаж, ажилтнуудын хувийн аюулгүй байдал, ашиглалтын нөхцөлийг хялбар байлгах шаардлагыг хангасан байх.

14.5.3 Хотын ногоон байгууламж дахь барилга байгууламж нь борооны усны урсцын хяналт, ашиглалтыг бүрэн харгалзан үзэх хэрэгтэй. Дээврийн налуу нь 15 градусаас бага буюу тэнцүү байна. Нэг эсвэл олон давхар барилгууд дээврийн ногоон байгууламжийг ашиглана.

14.5.4 Хотын ногоон байгууламжийг хашаа хана хийх нь тохиромжгүй, орон нутгийн нөхцөлийн дагуу хашааны оронд ногоон хана, цэцэг, таримал хашлага зэргийг орлуулан сонгож болно. Цэцгийн хана эсвэл хашлаганы өндөр нь 0.80 ~ 2.20м байх хэрэгтэй. Заавал хашаатай байх хотын ногоон байгууламж нь хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ USC0001-02:2019 дагаж мөрдөнө.

14.6 АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

14.6.1 Хотын задгай ногоон байгууламж дахь ариун цэврийн үйлчилгээний радиус 250м-ээс хэтрэхгүй байх. Баярын үеэр бие засах газар хангалтгүй тохиолдолд зөөврийн бие засах газрыг нэмж тохижуулж болно.

14.6.2 Ариун цэврийн байгууламжийн байршлыг зочид олоход хялбар, бие засах газрын гаднах байдал нь хүрээлэн буй орчинтойгоо уялдаж, өнгө үзэмжийг бууруулахгүй байхаар төлөвлөх.

14.6.3 Хотын задгай ногоон байгууламж дахь ариун цэврийн байгууламжийн тоо нь эрэгтэй, эмэгтэй тэнцүү эсвэл эмэгтэй их, эрэгтэй цөөн байхаар төлөвлөсөн байх.

14.6.4 Явган сууж бие засах газар нь бариултай байх.

14.6.5 Хотын ногоон байгууламж дахь ариун цэврийн байгууламж нь агаар, ус нэвтрэх, цэвэр, үнэргүй байхаар төлөвлөх.

14.6.6 Ариун цэврийн байгууламжийг халтиргаагүй шалаар тоноглож, хөлөөр ажилладаг эсвэл мэдрэгчтэй ус татах төхөөрөмж байрлуулах.

14.6.7 Ариун цэврийн байгууламжийн бохир усыг гол, нуур өнгө үзэмжийн усан сан руу шууд цутгахгүй бөгөөд усжуулж, хотын бохир усны хоолой руу оруулахаас өмнө стандартын дагуу цэвэршүүлсэн байх ёстой.

14.6.8 Тохижилт, цэцэрлэгжүүлэлт, үйлчилгээний ажилчдад гүйцэтгэж байгаа ажлын нөхцөлөөс нь хамааруулж зөөврийн ариун цэврийн байгууламжийг байршуулна.



Зураг 14.6 Зөөврийн ариун цэврийн байгууламж

14.7 ЦЭЦЭРЛЭГИЙН САНДАЛ, ХОГИЙН САВ, УНДНЫ УСАН ОРГИЛУУР

14.7.1 Хотын задгай ногоон байгууламжийг амрагчдын тоо, үзэмж сонирхох салхи нарнаас хамгаалах, борооноос хоргодох зэрэг хүчин зүйлийг харгалзсан сандлын тоог зохистой байрлуулж, амрагчдын тоонд харгалзуулан 20~50 ширхэг/га байхаар тохируулна.

14.7.2 Хотын задгай ногоон байгууламжуудын тэргэнцрийн зогсоолыг амрах суудлын хажууд 10% -аас доошгүй харьцаагаар тохируулна.

14.7.3 Сандлыг тууш үргэлжилсэн явган замын 50-100м тутамд байрлуулна (Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага UCS1404C:2020, 6.4-д)

14.7.4 Хотын ногоон байгууламжид хог хаягдлыг ангилах замаар цуглуулах зорилго бүхий хогийн сав байрлуулж, төв зам дээр 100м тутамд нэгээс илүү байх, амрагчид төвлөрсөн талбайд тоог зохих ёсоор нэмэгдүүлэх шаардлагатай.

14.7.5 Ундны усан оргилуурыг цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжид суурилуулсан байх ёстой бөгөөд ундны усан оргилуур, усны чанар нь ундны усны эрүүл ахуйн стандартыг хангасан байх.

14.7.6 Хотын ногоон байгууламжийн усан сангийн зураг төслийг ерөнхий төлөвлөлт, орон нутгийн байгалийн болон эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн боловсруулж, усан сан бүхий газрын хэлбэрийг орон нутгийн дүрэм журмын дагуу оновчтой хуваарилах, байгалийн усны эх үүсвэрийг үндэслэх нь зүйтэй.

14.7.7 Усан оргилуурын загварыг өдөр тутмын үйл ажиллагаанд тулгуурлан, хэлбэрийг нь үндэслэлтэй тодорхойлж, хүрээлэн буй орчинтой уялдаатай байлгах.

14.7.8 Өнгө үзэмжийн усан сангийн усыг цэвэр байлгахын тулд шүүх, эргэлт, цэвэршүүлэх техникийн арга хэмжээг хэрэгжүүлэх. Амрагчид гар хүрэх усан оргилууруудад дахин боловсруулсан ус хэрэглэж болохгүй.

14.7.9 Хотын ногоон байгууламжийн усны эрэг нь 1:2 ~ 1:6-ийн нам налуу байх. Усны түвшний харьцангуй их өөрчлөлттэй усны эргийн хувьд налуугийн хамгаалалт хийх шаардлагатай. Ногоон байгууламжийн усны эрэгт усны чанарыг цэвэршүүлж чадахуйц чийглэг, усны ургамал тарих хэрэгтэй.

14.8 ХИЙМЭЛ УУЛ БА ЧУЛУУЛАГ БАЙРЛУУЛАХ

14.8.1 Хотын ногоон байгууламжид байгалийн онцлогийг илэрхийлэхийн тулд хиймэл уул, хад чулууг оновчтой сонгон байршуулах. Хиймэл уулын чулуу нь цөөн бас хээнцэр байх.

14.8.2 Хиймэл уулын чулуулгийн ерөнхий хэлбэр, бүтцийг аюулгүй байдлын үүднээс төлөвлөж, хэлбэр дүрс нь бүрэн бүтэн, үзэсгэлэнтэй байх ба бат бөх, удаан эдэлгээтэй байх.

14.8.3 Хиймэл уулны чулууны хийц нь чулууны чанар, өнгө, бүтэц, хэлбэр, масштабын тодорхой дизайны шаардлагыг хангасан байна.

13.8.4 Хиймэл уулны чулуулагт байгалийн чулуунаас гадна хиймэл хуванцар чулуу ашиглаж болно.

14.8.5 Орон нутагт бие даан байрлуулсан үзэсгэлэнт чулуу нь цөөхөн бас хээнцэр, хүрээлэн буй орчинтойгоо уялдаатай байна.



Зураг 14.7 Цэцэрлэгжүүлэлтэд байрлуулсан хиймэл чулуу

14.9 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛСЭН ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ

14.9.1 Шөнийн цагаар нээлттэй хотын ногоон байгууламжийг цэцэрлэгийн гэрэлтүүлгээр тоногдсон байх. Цэцэрлэгийн гэрэлтүүлэг, зүлгэн дээрх гэрэл, ойсон гэрэл, талбайн гэрэл эсвэл хананы гэрлийг бодит хэрэгцээнд нийцүүлэн сонгох хэрэгтэй.

14.9.2 Цэцэрлэгийн гэрэлтүүлгийн дизайныг хүрээлэн буй орчинтой уялдуулж, цэцэрлэгийн гэрэлтүүлэг нь өнгө үзэмжийн нэг хэсэг болгон төлөвлөх шаардлагатай.

14.9.3 Ногоон байгууламжийн гэрэлтүүлэгт нарны энергийг ашигласан эрчим хүчний хэмнэлттэй гэрлийг ашиглах нь зүйтэй.

14.9.4 Ногоон байгууламжийн өнгө үзэмжийн гэрэлтүүлэг ба гэрэлтүүлгийн тохижилт нь гэрлийн тохиромжгүй нөлөөллөөс зайлсхийх, экологи орчныг хамгаалах шаардлагыг харгалзан үзэх ёстой. Гадна гэрэлтүүлгээс гарсан гэрэл нийт гэрлийн урсгалын 25% -аас хэтрэхгүй байх.

14.9.5 Гаднах гэрэлтүүлгийн цахилгаан түгээх систем нь ирж буй цахилгаан хангамжийн үед засварын тусгаарлах функц бүхий дөрвөн түвшний унтраалгаар тоноглогдсон байх.

14.9.6 Хотын задгай ногоон байгууламж дахь олон нийтийн утасны бүхээг, кабелийн өргөн нэвтрүүлгийн системийг бий болгосон байна.


14.10 ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛСЭН ТАЛБАЙН УРАН БАРИМАЛ

14.10.1 Хотын ногоон байгууламж дахь баримлын сэдэв, хэлбэр, материал, хэмжээ нь хүрээлэн буй орчинтойгоо уялдаж байх.

14.10.2 Хотын ногоон байгууламжид дурсгалын баримал, томоохон хэмжээний баримлыг сайтар сонгож, холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж батлуулах.

14.11 МОД, ТАРИМАЛ УРГАМЛЫН ЗУРАГ ТӨСӨЛД АШИГЛАГДАХ ТЭМДЭГЛЭГЭЭ

14.11.1 Тэмдэглэгээ нь одоогийн улсын стандартад заасан олон нийтийн мэдээллийн графикийг баримтална.




Зураг 14.7 Навчит, мод, сөөгийн тэмдэглэгээ

Зураг 14.8 Шилмүүст модны тэмдэглэгээ



Зураг 14.9 Хэлбэржүүлээгүй зүлэг



Зураг 14.10 Холимог зүлэг (цэцэг, зүлэг)



Зураг 14.11 Хэлбэржүүлсэн зүлэг

14.12 ТОГЛООМ, ДАСГАЛЫН ТӨХӨӨРӨМЖ

14.12.1 Хотын ногоон байгууламж дахь хүүхдийн тоглоом, насанд хүрэгчдийн дасгалын тоног төхөөрөмж нь аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байх ёстой бөгөөд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийсэн байх.

14.12.2 Хүүхдийн тоглоомын талбайнууд нь зөөлөн бүтэцтэй эсвэл цэвэр элс байх. Элсний талбайн эргэн тойронд элс тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

14.12.3 Хүүхдийн тоглоомын талбайд тоглоомыг насны ангиллаар хуваарилан суурилуулж, талбайг таримал хашлагаар зааглаж өгнө.

14.12.4 Бага насны хүүхэд, сургуулийн өмнөх насны хүүхэд, сургуулийн насны хүүхдүүдэд (бага анги, дунд анги, ахлах анги) зориулагдсан байна.

14.12.5 Хүүхдийн тоглоомын талбай нь нэгдсэн хогийн цэгээс 100м-ээс багагүй зайд байрлуулна.

14.12.6 Тоглоомын талбайн байршлыг сонгохдоо Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл аюулгүйн орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019-ыг дагаж мөрдөнө.

14.13 УСАН ХАНГАМЖ

14.13.1 Усан хангамжийн зураг төсөлд төрөл бүрийн усны нийт хэрэглээ болох ахуйн ус, гал түймэртэй тэмцэх ус, зам цацах ус, цэцэрлэгжүүлэлтэд ашиглах ус, усан сан бүхий ус, хоолойн сүлжээ алдагдах, урьдчилан тооцоолоогүй усны хэрэглээ гэх мэтийг үндэслэн ерөнхий усны хэмжээг тооцно.

14.13.2 Ногоон байгууламж дахь дотоодын усан хангамжийн систем нь бусад усан хангамжийн системтэй холбогдож болохгүй. Холбох шаардлагатай үед дотоодын усан хангамжийн систем дэх буцах урсгалын бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

14.13.3 Ногоон байгууламжийн усалгааны ус дамжуулах хоолойн сүлжээ нь газрын гадаргаас эхлэн тооцоолж усны хамгийн бага даралт нь 0.10 МПа байх хэрэгтэй.

14.13.4 Ногоон байгууламжид ус хангамж шаардлагатай толгод, өндөр газарт хүрэх усалгааны шүршигч ба усан цорго нь даралтын тодорхой шаардлагыг хангасан байна. Үйлчилгээний усны хамгийн бага даралтыг бодит шаардлагын дагуу тооцоолох хэрэгтэй.

14.13.5 Усан хангамжийн хоолойг тухайн газартай уялдуулан байрлуулсан байх. Шугам хоолойн системийн өндөр, гүдгэр хэсгүүдэд яндангийн автомат хавхалгыг, дамжуулах хоолойн системийн нам хотгор хэсэгт ус зайлуулах хавхалгыг угсарна.

14.14 УС ЗАЙЛУУЛАХ

14.14.1 Ус зайлуулах системийг орон нутгийн хотын ус зайлуулах систем, хүрээлэн буй орчныг хамгаалах болон бусад хүчин зүйлийг харьцуулж үзсэний дараа тодорхойлно.

14.14.2 Ногоон байгууламжаас ус зайлуулах зорилгоор борооны ус, бохир усыг салгаж урсах голдирлыг бий болгоно. Бохир усыг усан сан руу шууд хаях ёсгүй бөгөөд стандартын дагуу цэвэрлэсний дараа зайлуулах.

14.14.3 Ногоон байгууламж дахь борооны ус зайлуулах хоолойн зураг төслийг боловсруулахдаа ногоон байгууламжийн янз бүрийн чиг үүргийн дагуу борооны усны урсцыг хянах, ашиглах техникийн арга хэмжээг сонгоно.

14.14.4 Химийн үйлдвэрүүд, халдварт өвчний эмнэлгүүд, газрын тосны агуулахууд, шатахуун түгээх станцууд, бохир ус цэвэрлэх байгууламжууд, хогийн цэг зэргийн ногоон байгууламжид борооны ус нь нэвчих ёсгүй.



Зураг 14.12 Борооны усны урсах чиглэл

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа БД 11-102-07.
2. Дуу чимээ тусгаарлалт БНБД 23-05-10.
3. Ландшафтын архитектурын зураг төслийн стандарт СЖТ/Т 67-2015.
4. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030.
5. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
6. Москва хотын ногоон байгууламжийг бий болгох, хамгаалах, арчлах журам; М., 1999. ОХУ-ын Госстрой. Улсын аж ахуйн нэгжийн нийтийн аж ахуйн академи. К. Д. Памфилов. (MDS 13-5.2000)
7. Модлог болон сөөглөг ургамлын барилгаас алслагдах зай. МГСН 1.01 – 2001
8. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030).
9. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандал UCS 1404C:2020.
10. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага UCS1403C:2020.
11. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага UCS1901B:2020.
12. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлт GB 51192-2016.
13. Орон сууцны хорооллын ногоон байгууламж DG5301/Т 21-2017.
14. Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага UCS0902B:2020.
15. Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-06.
16. Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага UCS0903B:2020.
17. Үзэсгэлэнт болон түүхэн газруудын ерөнхий төлөвлөлтийн стандарт GB/T 50298-2018.
18. Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019.
19. Хот, тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04.
20. Хот суурины гудамж, зам төлөвлөлт БНБД 32-01-04.
21. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04.
22. Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар УБ11-202-00.
23. Хотын ногоон байгууламжийг төлөвлөх стандарт GB/T51346-2019.

24. Хотын ногоон байгууламжийн ангиллын стандарт CJJ / Т 85-2017.
25. Хотын ногоон байгууламжийн төлөвлөлт GB 50420-2007 (2016) .
26. Хотжилт ба эрүүл мэнд хөтөлбөр.
27. Хотын ногоон байгууламж. Тодорхойлолт ба нэр томьёо. ГОСТ 28329 – 89
28. Хотуудын ногоон байгууламж. Нэр томьёо, тодорхойлолт. ГОСТ 28329-89.
29. Хотын ногоон байгууламжийг байгуулах ба хамгаалах, зохион байгуулах дүрмийг батлах тухай. ГОСТРОЯ РФ ОТ 15.12.99. N153.
30. Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага MNS6263:2011.
31. Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн төлөвлөлт DG5301/Т 19-2017.
32. Цэцэрлэгт хүрээлэн төлөвлөлтийн удирдамж GB 51192-2016.
33. Эрүүл ахуйн тухай хууль.
34. Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага UCS0901B:2020.
35. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6055:2009.
- <https://estandard.gov.mn/>
 - <https://mofa.gov.mn/exp/>
 - <https://www.mlsp.gov.mn/>
 - <https://standartgost.ru/>
 - <http://www.quihuadaohang.com/>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



70118060



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар